

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2018



**APU COMPANY**  
Absolute. Pure. Unique.

# АГУУЛГА

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

ЭРХЭМ ЗОРИЛГО	6
ҮНЭТ ЗҮЙЛС	7
БИДНИЙ БАРИМТЛАЛ	8
ТҮҮХЭН ТОВЧООН	10
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ	13
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ	14
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ	16

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СТРАТЕГИ БА БИЗНЕСТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ	20
Компани ба хүний нөөц	
Үнэ цэнэ	
Үйл ажиллагаа	
ЭКСПОРТ	24
ҮЙЛ АЖИЛЛАГАА	25
Үнэ цэнийн гинжин хэлхээ	
Бизнес нэгжүүдийн танилцуулга	
Чанарын бодлого	
ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД	30
2018 ОНЫ НЭГДСЭН БРЭНДҮҮД	36
Архины брэндүүд	
Шар айргийн брэндүүд	
Ус, ундаа, шүүсний брэндүүд	
Сүү, сүүн бүтээгдэхүүний брэндүүд	
ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД	46

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	48
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	
Охин компаниудын мэдээлэл	
НЭГДЛИЙН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	49
2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	50
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ	51
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	52
ТУЗ-ийн бүрэлдэхүүн	
ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн	
2018 оны ТУЗ-ийн хурлын статистик	
ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ	55
Сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны мэдээлэл	
Ногдол ашгийн мэдээлэл	
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ	58
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	60
Эрсдэлийн удирдлагын бодлого	
2019 онд учирч болох өндөр эрсдэлүүд	

**ТОГТВОРТОЙ БАЙДАЛ**

ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	62
ЭРХЭЛСЭН ЗАХИРЛЫН ЯРИЛЦЛАГА	
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО	64
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	66
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БИД	68
ШАГНАЛ	70

**ТАЙЛАГНАЛ**

САНХҮҮГИЙН ТАЙЛАН	72
Санхүүгийн байдлын тайлан	
Дэлгэрэнгүй орлогын тайлан	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	
Мөнгөн гүйлгээний тайлан	
Тайлагналын зарчим	
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд	
ТАЙЛБАР ТОЛЬ	80







# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нийгэмд баялаг бүтээх тулгуур хүч нь болж, өөрсдийн гаргасан амжилтаараа хүн, байгаль дэлхий, ирээдүйдээ хувь нэмрээ оруулахад оршино.

# БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

## Бизнес эрхлэлт:

Бид бүх шатанд багаар ажиллан хамтран туурвиж, хүмүүсээ зоригжуулан дуудаж, урамшуулан тэтгэн, тэргүүлэгч болохын төлөө эрмэлзэнэ.

## Ил тод байдал:

Ил тод байдлыг эрхэмлэн, хийж буй ажилдаа бусдыг татан оруулж, урамшуулахын тулд зорилгоо бүрэн таниулна.

## Өвөрмөц байдал:

Бид тулгарсан сорилт бүрийг даван туулж, хамтран ажилладаг туншүүд, нийгэмдээ дэмжлэг үзүүлэх ухаалаг замуудыг эрэлхийлнэ.

## Чин шударга байдал:

Бид хийж байгаа зүйлээ үнэнч шударга, ёс суртахууны сахилга баттай гүйцэтгэж, Монгол улсын байгалийн баялгийг хойч үедээ өвлүүлэн үлдээж, дээд зэргийн стандартуудыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нэвтрүүлж, цаашид улам хөгжүүлэхийн төлөө ажиллана.

# БИДНИЙ БАРИМТЛАЛ

## ТӨГС, ТӨГӨЛДӨР, ТУНГАЛАГ Absolute, Pure, Unique

Монголын уламжлалт нүүдэлчдийн соёл, гүн ухаанд тэнгэрийг цэвэр хязгааргүйн билэгдэл, байгаль дэлхийг цаг хугацаа, оюун ухааны хосгүй нэгдэл гэж үздэг. Энэ хоёр ижилгүй шинж нийлэн цэвэр ариун чанарыг он удаан жил хадгалж иржээ. “Төгс, Төгөлдөр, Тунгалаг” гурвалын холбоосыг “Хамгийн Шилдэг”-ээ гэж дээдлэх Монгол уламжлалаар “Дээж” болгон өргөн барьж байна. Энэхүү бэлэгдэлээ бид бизнесийнхээ цөм болгон, хийж байгаа бүхнээ улам сайжруулахыг эрмэлздэг. Бид хөрөнгө оруулалалт болон ажилчдынхаа хөдөлмөр зүтгэлээр бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ эрхэм үйлчлүүлэгч болон нийгэмдээ зориулж цаг ямагт төгс болгохын төлөө хичээх болно.



## ТӨГС

### Үүрэг хариуцлага

- Бид хөгжлийг хөтөлж, нийгмийг манлайлан, зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулна.
- Компанийн санхүү, мэдээллийг ил тод, үйл ажиллагааг тогтвортой байлгана.
- Монголын тэргүүлэгч ажил олгогч байна.

## ТӨГӨЛДӨР

### Соёл, бүтээгдэхүүн

- Орчин цагийн зах зээлийг манлайлан тодорхойлж, хүнсний монгол брэндийг бүтээн үйлдвэрлэгч байна.
- Дэлхийн түвшний бизнесийн байгууллагуудтай түншилж, хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монголын хэл, соёлын өвөрмөц өвийг хадгалан хамгаалж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## ТУНГАЛАГ

### Ёс зүй, орон зай

- Бид хүн, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, үнэт зүйлээ дээдэлнэ.
- Компанийн хөгжил нь үйлдвэрлэлийн шинэ технологи дээр суурилна.
- Бизнесийн ил тод байдал, аюулгүйн нөхцөлийг хангаж ажиллана.

# ТҮҮХЭН ТОВЧООН

1924  
Монгол Ардын Намын Төв хорооны V хурал, Ардын засгийн газрын VII хурлаар "Архины онц эрхийг улсын санд авах тухай" дүрмийг баталжээ. Ийнхүү Улаанбаатар хотод 14 ажилтантай анхны архины үйлдвэр нээгджээ.

1958  
Шар айрагны үйлдвэрт хөргөлт, даралтат хийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулж, цагт 3000 шил шар айраг савлах хүчин чадалтай механикжсан урсгал шугамыг ашиглалтанд оруулан, техник технологийн дэвшилт хийв.

1971  
Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг сайн зохион байгуулж, оногдоон үүргээ амжилттай биелүүлсэн учир Архи пивоны төв үйлдвэрийг БНМАУ-ын Засгийн газрын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнажээ.

1973  
БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1973 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн 10-р тогтоолоор Архи пивоны төв үйлдвэрийг Улаанбаатарын Архи пивоны комбинат (АПК) гэж нэрлэхээр тогтов.

1992  
Архи, пивоны комбинатыг АПУ ХК болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувийг төрийн мэдэлд үлдээж, 49 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалсан.

1927

Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анхны шар айраг үйлдвэрлэж эхэлсэн.

1961

Хийжүүлсэн амтат ундаа, Жанчивлангийн рашаан савлах цехийг шинээр байгуулжээ.

1972


ЗХУ-ын тусламжтайгаар Архи, пивоны комбинатын барилга, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгаж, тохируулга, туршилтын ажлыг хийж, 1972.12.31-ний өдөр БНМАУ-ын Засгийн газрын актаар байнгын ашиглалтанд оруулжээ.

1981

Архи пивоны комбинат 1976 оноос эхлэн 5 жил дараалан Улсын тэргүүний үйлдвэрээр шалгарч, төрийн дээд шагнал "АЛТАН ГАДАС" одонгоор шагнуулжээ. Монгол хүн анх удаа сансарт ниссэн үйл явдалд зориулан дээд зэргийн "Болор" архийг хэрэглэгчдэдээ хүргэж эхэллээ.

2001

11 дүгээр сард Монгол Улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын салхийг хагалж, компанийн төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг дуудлага худалдаанд оруулснаар АПУ ХК хувийн өмчид бүрэн шилжив.







## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч Та бүхний амар мэндийг эрэн мэндчилье.

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигч Та бүхэн Монгол Улсын аж үйлдвэрийн салбар, хөрөнгийн зах зээлийн түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн бизнесийн нэгдэл байгуулах шийдвэрийг 2017 оны зун гаргаж байлаа. Уг шийдвэрийн дагуу шингэн хүнсний зах зээлийг тэргүүлэгч компаниуд нэгдэж, 2000 гаруй гишүүнтэй хамт олон "НЭГ ГЭР БҮЛ, НЭГ ЗОРИЛГО" уриан дор хүчээ нэгтгэснээс хойш бүтэн нэг жилийг үдэж байна. Энэ хугацаанд "PEOPLE, VALUE, PROCESS" буюу Хүний хөгжилд төвлөрсөн, Бизнесийн үнэ цэнийг өсгөж, ажлын явцаа нэгтгэн ижилсүүлэх нүсэр ажлын ард гарч, үр дүнгээ дүгнэх цаг ийнхүү ирлээ.

АПУ ХК 2018 онд зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа бататгаж, ашиг орлогоо өсгөн, амжилттай ажилласан хэмээн Төлөөлөн Удирдах Зөвлөл дүгнэж, нэгж хувьцаанд 46 төгрөг буюу нийт 49 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. Энэ бол Монголын хөрөнгийн биржийн хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани болох АПУ ХК хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг бүрэн дааж буйн илрэл юм.

Бид ирэх жилүүдэд ашигт ажиллагаагаа тогтвортой өсгөх, бизнесийн цар хүрээгээ тэлэх зорилтуудаас гадна тогтвортой хөгжлийн үндэс сууриа бэхжүүлэн, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг бүрэн нэвтрүүлэхийг зорьж байна.

АПУ ХК үйлдвэрлэлдээ нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, 2019 онд үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хатуу ба шингэн хаягдлын менежментийг шинэ шатанд гаргахад чиглэсэн дорвитой хөрөнгө оруулалт хийх болно.

Бидэнд өндөр итгэл хүлээлгэн, үргэлж дэмжиж ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ, амжилт ололт бүхний ард хичээл зүтгэлээ зориулан ажилладаг АПУ ХК-ийн удирдлагууд, нийт ажиллагсдадаа чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

Пүрэвийн БАТСАЙХАН



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, харилцагчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе!

2018 он “АПУ” ХК-ийн хувьд бизнесийн нэгдлийн дараах үйл явц өрнөсөн онцгой жил байлаа. Нэгдсэний үр дүнд 94 сая ам.долларын зээлийн эргэн төлөлтийг хугацаанаас нь өмнө дуусгасан таатай мэдээгээр өнгөрсөн оноо үдэж байна.

Улс орныхоо өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан, улсын төсөвт нийт 269.7 тэрбумын татвар төлж, 57.8 тэрбумын ашигтай ажиллалаа. Тогтвортой ажлын байраар хангах бодлогын хүрээнд нийт ажилчдын тоо одоогийн байдлаар 2,063 болж өссөн. Нэг нэгэнтэйгээ мэдлэг туршлагаа хуваалцах, суралцах, хөгжих, соёлоо нэгтгэх талаар компани хөрөнгө зарцуулж, хүн бүр хичээсний үр дүнд бид хамтдаа олон төсөл хөтөлбөр хэрэгжүүллээ.

Урьд өмнө зарим бүтээгдэхүүнийг зөвхөн “АПУ” үйлдвэрт үйлдвэрлэдэг байсан бол “Тайгер” шар айргийн үйлдвэрт үйлдвэрлэх, эргээд “Тайгер” үйлдвэрийн бүтээгдэхүүнийг “АПУ” үйлдвэрт үйлдвэрлэх гэх мэт үйл ажиллагааны өөрчлөлтийг Нэгдлийн хүрээнд хийж эхлээд байна. Нэгдсэн “АПУ” компанийн хувьд 260 нэр

төрлийн 176.1 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, шинээр “Ауруг”, шинэчлэгдсэн “Ерөөл” болон “Шинэ Улаанбаатар” мөн, шар айргийн төрөлд “Сэнгүр” (2,4 литр ПЕТ савлагаа) брэндүүдийг, АПУ Дэйри компанийн хувьд “Сайн” брэндийн гишүүнэ, интоортой йогурт, бууцай, кивитэй йогурт, Сайн Плас брэндийн эслэгээр баяжуулсан йогурт, “Дээж” брэндийн ааруул, масло, бор сахартай таргийг тус тус худалдаанд гаргалаа.

Түүнчлэн бидний 2018 оны стратеги зорилтуудын нэг болох “Brewing Better World” буюу “Сайхан дэлхийг цогцлооё” стратегийн хүрээнд байгаль орчинд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүллээ. Хог хаягдлын менежментийн төслийн хүрээнд “Эргэлтийн болон эргэлтийн бус төрлийн лонхны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх” дэд төслийн хүрээнд гадагшаа чиглэсэн гадаад валютын мөнгөн урсгалыг хааж, дотоодоос татан авах боломжтой эргэлтийн болон эргэлтийн бус лонхны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, татан авалтыг эрчимтэй зохион байгуулж, байгаль орчинд ялангуяа хөдөө орон нутагт хаягдаж буй хог хаягдлыг бууруулах төслийн эхний ажлуудаа хийж эхлээд байна. Усны менежментийн болон эрчим хүчний хэрэглээг бууруулах төслүүдийг хэрэгжүүлж, тодорхой хэмжээний хэмнэлт бий



болголоо. Үйлдвэрлэлийн ханган нийлүүлэлтийг зөв төлөвлөж, нийт 3 тэрбумын худалдан авалтын хэмнэлт хийж, чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандарт нэвтрүүлж, олон улсын “SGS” аудитын компаниар баталгаажуулан, гэрчилгээгээ гардан авсан зэрэг ололт амжилт дүүрэн жил байлаа.

Компани байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг чиглэлээ болгож, цаашдын хэтийн хөгжлөө тодорхойлох бөгөөд дэлхий даяарх “Эко” үйлдвэрлэлийн Монгол дахь жишиг компани болох алс хэтийн зорилт үүнд багтаж байна. 2018 оноос эхлэн “HEINEKEN” компанийн стандартын дагуу уур дулаан, саарал ус, CO<sup>2</sup> зэрэг үйлдвэрлэлийн үйл явцыг судалж, тоон мэдээллийг гаргаж эхэлсэн бөгөөд 2019 оноос эхлэн харьцуулсан анализыг гаргах боломж нээгдэх юм.

Бидний хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд хагас тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 томоохон төсөл, хөтөлбөрийг дэмжин ажилласан бөгөөд цаашид “Зөв зохистой хэрэглээ”-г олон нийтэд таниулах чиглэлээр түлхүү анхаарч Улаанбаатар хот, 21 аймагт байгаа 8000 гаруй харилцагч, борлуулах цэгүүд, үйл ажиллагаа явуулж буй газруудтай хамтран мэдээлэл сургалт, таниулах ажил хийхээр төлөвлөж байгаа билээ.

2018 онд компанийн хэмжээнд мөрдөх “Бизнесийн ёс зүйн дүрэм” –ээ баталж, хувь хүний ёс зүй, худалдааны ёс зүй, компанийн ёс зүйн тухай сургалтуудыг охин компанийн бүх ажилчдад мэдээлэн таниулах ажлыг зохион байгууллаа. “HEINEKEN” компанийн стандартын дагуу аюулгүй ажиллагааны дүрэм журмуудыг баримтлан ажиллаж, видео материал бэлтгэн, мэдээлэл олгох сургалт, сурталчилгаа хийж, мөрдлөг болгон ажиллаж байна.

Борлуулалтын хувьд “HEINEKEN”-ийн дэлхий даяар ашигладаг шилдэг туршлага болох “Борлуулалтын

цэг дээрх төгс гүйцэтгэл”-ийн EOE (Excellent Outlet Execution) системийг 2018 оноос амжилттай нэвтрүүлж эхэлсэн бөгөөд сар бүр үзүүлэлт нь тогтмол өссөөр байна. Бид 2019 онд 179.9 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, “АПУ” компанийн хэмжээнд 626.4\* тэрбум төгрөгийн борлуулалтын гүйцэтгэлтэй ажиллахаар төлөвлөсөн.

Дотоодын зах зээлд өөрсдийн бий болгосон туршлагадаа үндэслэж, 2018 оноос экспортыг цаашдын үйл ажиллагааны гол чиглэлээ болгон хөгжүүлэх зорилт тавьсан. Бидний хувьд ОХУ болон БНХАУ-ыг стратегийн хоёр үндсэн зах зээл гэж харж байгаа бөгөөд энэ хүрээнд тухайн бүс нутагт нэр хүндтэй, борлуулалтын нэгдсэн сүлжээ бүхий хамтрагчидтай гэрээ хэлэлцээр байгуулж эхлээд байна.

Монгол Улсын хүнсний ууган үйлдвэрлэгч, АПУ ХК үүсч байгуулагдсаны 95 жилийн ойн босгон дээр бидэнтэй хувь заяагаа холбож, бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж, хамтран ажиллаж ирсэн Та бүхэнд талархал дэвшүүлж, өнгөрсөн амжилтаа бататгаж, 2019 ондоо илүү их хөгжил дэвшлийг бий болгож, амжилтын гарааны жилийг хамтдаа эрч хүчээр дүүрэн, хүсэл зорилго нэгтгэйгээр эхлүүлэхийг хүсэж байна.







ХАМТДАА ИЛҮҮ ХҮЧТЭЙ!

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

\*Нийт борлуулалтын орлого

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ<sup>1</sup>



<sup>1</sup>2018 он нь АПУ Групп компанийн нэгдлийн анхны жил бөгөөд дээр дурдсан 2018 оны үзүүлэлт нь Групп компанийн үзүүлэлт болно.



## ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		Аудитлагдаагүй санхүүгийн тайлан 2018	Аудитлагдсан санхүүгийн тайлан 2017	Өсөлт %
<b>БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ</b>	мян.литр	<b>133,446</b>	93,296	43%
<b>ОРЛОГО ҮР ДҮН</b>				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	<b>512,928</b>	234,039	119%
Татварын өмнөх ашиг	сая.төг	<b>77,083</b>	33,317	131%
Татварын дараах ашиг	сая.төг	<b>57,852</b>	23,938	142%
<b>БАЛАНС</b>				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	<b>185,830</b>	172,396	8%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	<b>344,616</b>	368,339	-6%
Нийт хөрөнгө	сая.төг	<b>530,447</b>	540,735	-2%
Нийт өр төлбөр	сая.төг	<b>86,269</b>	148,296	-42%
Нийт эздийн өмч	сая.төг	<b>444,178</b>	392,439	13%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	<b>530,447</b>	540,735	-2%
<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	<b>88,166</b>	48,533	82%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	<b>(13,520)</b>	24,451	-155%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	<b>(63,971)</b>	(38,625)	66%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	<b>10,674</b>	34,359	-69%
<b>ТАТВАР ТӨЛӨЛТ</b>				
Онцгой албан татвар	сая.төг	<b>177,756</b>	95,030	87%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	<b>55,273</b>	20,713	167%
Бусад	сая.төг	<b>36,731</b>	13,621	170%
Нийт	сая.төг	<b>269,760</b>	129,364	109%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	<b>13,520</b>	5,138	163%





**БИЗНЕСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

# СТРАТЕГИ БА БИЗНЕСТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

2018 онд АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-г амжилттай нэгтгэсэн нь Монгол улсын түүхэн дэх бизнесийн хамгийн том нэгдэл боллоо. Уг нэгдлийн үйл ажиллагааг дараах зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлээ.

## Нэгдлийн зорилго

- Монгол Улсад тэргүүлэх аж ахуйн нэгжийн байр сууриа хадгалж бэхжүүлэх.
- Нэгдлийн өгөөжийг бодит, өндөр түвшинд байлгах.
- Нэгдлийн оролцогчдын, олон улсын стандартад тэнцсэн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг хэвээр хадгалах, төгөлдөршүүлэх.
- Нийгмийн хариуцлага хүлээж тогтвортой хөгжихийг эрхэмлэх.
- Олон улсын зах зээлд нэвтрэх.

## Зорилт, зарчмууд

- Нэгдлийн үнэ цэнэ, бизнесийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилтод захируулан бүтэц, үйл ажиллагаагаа шинэтгэх
- Нэгдлийн оролцогч компаниудын дотоод, эрүүл өрсөлдөөнийг дэмжих
- Олон улсын зах зээлд тэргүүлдэг компаниудын үйл ажиллагаагаар шалгарсан туршлагыг нэвтрүүлэх
- Нэгдсэнээр бий болсон бизнесийн шинэ боломж, нөөц, чадавхийг нийгэмд таниулах
- Компанийн, олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах

Компаниудыг нэгтгэж, дурдсан зорилго зорилтод хүрэхийн тулд “Bain & Company” ОУ-ын зөвлөх үйлчилгээний компанийг хөлслөн, хоёр үе шаттай ажиллуулсан нь амжилттай боллоо. Нэгдлийн оролцогч компаниудыг уялдуулан шинэтгэх ажлыг дараах гурван чиглэлээр хийж гүйцэтгэсэн. Бид 2018 онд компанийн хэмжээнд дараах нэн тэргүүний асуудлуудыг дэвшүүлж ажилласан.



### КОМПАНИ БА ХҮНИЙ НӨӨЦ

- Компани (нэгдэл)-ийн бүтэц, засаглалын шинэтгэл болон хүний нөөцийн нэгдсэн бодлого, хуваарилалт



### ҮНЭ ЦЭНЭ

- Үнэ цэнийг нэмэгдүүлэх боломж, санаачлагыг дэмжиж, шинэтгэлийн өгөөжийг нэмэгдүүлэх стратеги



### ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Компаниудын үйл ажиллагааг уялдуулан шинэтгэх
- Мэдээллийн нэгдсэн систем

## КОМПАНИ БА ХҮНИЙ НӨӨЦ



### Компани:

- Нэгдлийн өгөөж, бүтээмжийг бодит, өндөр түвшинд хүргэхээр төлөвлөж, бүтэц, зохион байгуулалтаа шинэчилсэн.
- Компанийн бүтцэд Стратегийн газар, Байгууллагын харилцааны газрыг, түүнчлэн гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Гадаад худалдааны газрыг шинээр байгуулсан.
- Компанийн засаглалын циклийг өөрчилж, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, түүний хүрээнд жилийн төлөвлөгөөг тус тус боловсруулан ТУЗ-өөр батлуулж хэрэгжилтийг улирлаар хянаж байгаа нь төлөвлөгөөг бүхэлд нь бүрэн, бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

### Хүний нөөц:

- Хамт олны нэгдмэл байдлыг бүрдүүлэхийн тулд “Нэг гэр бүл – Нэг зорилго” уриан дор хүний нөөцийн нэгдсэн, цогц бодлогыг олон улсын стандартын дагуу хэрэгжүүллээ.
- Нэгдлийн өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажилтан тус бүрийн эрх, үүрэг, хариуцлагыг оновчтой тодорхойлж, хөдөлмөрийг зөв хуваарилсан.
- Олон улсын түвшинд ажиллах чадвар бүхий, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, дадлагажуулахад онцгойлон анхаарч сургалт, хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж амжилттай хэрэгжүүллээ.

## ҮНЭ ЦЭНЭ

Компанийн үнэ цэнэ болон бизнесийн өгөөжийг нэмэгдүүлж, нэгдлийн дараах хамтын үр ашгийг сайжруулахын тулд дараах стратегиудыг баримтлан ажиллалаа.

### АШИГ ОРЛОГОО НЭМЭГДҮҮЛЭХ, ИННОВАЦИЙГ ДЭМЖИХ

#### Стратеги

- Экспортод тулгуурлан зах зээлээ тэлэх
- Тоо хэмжээнээс илүү үнэ цэнэд төвлөрөх
- Инновацид суурилсан бизнес

#### Үйл ажиллагаа

- Экспортод төвлөрч, үйл ажиллагааг өргөжүүлэн Гадаад худалдааны газар байгуулж, экспортын стратегийг боловсруулж, баримтлан ажиллалаа
- Брендийн багцыг оновчтой болгож, ашигтай брендүүддээ төвлөрч, нөөцийг зөв зохистой хуваарилж ажиллалаа
- Бизнесийн бүтцийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Ус, ундааны бизнесийн нэгжийг Low and Non-Alcoholic шингэн хүнсний бизнес нэгж болгон өргөжүүлж, инновацид суурилан эрүүл мэндэд тустай, байгалийн гаралтай олон талын ач холбогдолтой шинэ бүтээгдэхүүнүүдийн судалгаа хөгжлийг боловсрууллаа

### БИЗНЕСИЙН БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

#### Стратеги

- Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны нийт бүтээмж, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх
- Зардал хэмнэх

#### Үйл ажиллагаа

- Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны үр ашигт уялдааг хангах зорилгоор олон төслүүдийг санаачлан хэрэгжүүлж, үйл ажиллагааны стратегид суурилсан цогц бодлогыг баримтлан ажиллалаа
- Нэгдлийн өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагааны бүх түвшинд зардал хэмнэх F.O.R.C.E төсөл болон бусад санал санаачлагуудыг амжилттай хэрэгжүүллээ

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭХ

#### Стратеги

- Аюулгүй байдлыг эрхэмлэх
- Хариуцлагатай хэрэглээг түгээх
- Байгаль, дэлхийд ээлтэй үйл ажиллагааг баримтлах

#### Үйл ажиллагаа

- Нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд зөв зохистой хэрэглээг түгээх, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд үйл ажиллагааны бүхий л түвшинд аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж, цэвэр ус, эрчим хүчний хэрэглээгээ бууруулж, үйлдвэрээс гарах хог хаягдлыг дахин ашиглах төсөл хэрэгжүүлэн ажиллалаа

### ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, ХАМТ ОЛНЫ НЭГДМЭЛ БАЙДАЛ

#### Стратеги

- Хүний нөөцийг чадавхижуулах, хөгжүүлэх
- Хойч үеэ манлайлах, залгамж халаа бэлтгэх

#### Үйл ажиллагаа


- Хүний нөөцийн нэгдсэн бодлого боловсруулж, ажилчдын сургалт хөгжил, манлайлал, залгамж халаа бэлтгэх болон хувийн хөгжилд онцгой анхаарч, хамт олны нэгдмэл байдлыг нэмэгдүүлэх олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа

## ҮЙЛ АЖИЛЛАГАА


### Үйл ажиллагааг шинэтгэх

Компанийн бүтээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахын тулд групп компани дахь алба нэгжүүдийн хамтарсан “Нэгдлийн менежментийн баг”-г байгуулж, бүх хэсэгт удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллалаа. Тус хороо нь үндсэн хоёр чиглэлийн хүрээнд ажилласан юм.

#### Бүтэц, зохион байгуулалт:



#### Үр ашигт байдал:



### Мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх

Нэгдэлд оролцогч компаниудыг мэдээллийн нэгдсэн систем болон дэд бүтцээр хангах, үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах програм хангамжийг шинэчлэх зорилгоор ERP-г амжилттай нэвтрүүллээ. 2018 онд:


- Мэдээллийн системийн нэгдсэн дэд бүтцээр хангах ажил бүрэн хэрэгжиж дууссан
- Програм хангамжийн шинэчлэлийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй байсан ба 2019 онд бүрэн дуусгахаар төлөвлөж байна.

# ЭКСПОРТ

## ҮНДСЭН ЗАХ ЗЭЭЛ



БНХАУ



ОХУ



Татваргүй  
бараа



## БУСАД ЗАХ ЗЭЭЛ



БНСУ



ЯПОН



Европын  
Холбооны  
улсууд

Бид ОХУ болон БНХАУ-ыг экспортын гол зах зээлээ болгон түшиглэн, БНСУ, Япон болон Европын зарим орнуудад бүтээгдэхүүнүүдээ экспортлож байна

## Экспортын брэндүүд



**ЧИНГИС ХААН**  
(0.75л, 40%)



**СОЁМБО**  
(1л, 0.75л 39.5%)



**БОЛОР**  
(1л, 0.75л, 39%)



**АРХИ**  
(0.75л, 0.5л, 0.35л,  
35%, 38%, 39.5%)



**АЛТАН ТҮРҮҮ**  
(0.75л, 0.5л, 38.5%)



**ЧИНГИС ХААН**  
(0.33л, 5.0%)



**НИЙСЛЭЛ**  
(0.45л, 0.5л, 2.5л, 5%)



**СЭНГҮР**  
(0.45л, 0.5л, 2.4л,  
30л, 4.8%)



**АЛТАН ГОВЬ**  
(0.33л, 0.45л,  
0.5л, 5л, 5.1%)



# ҮЙЛ АЖИЛЛАГАА

## АПУ ОРЦ



### САНХҮҮ

Хувь нийлүүлэгчдийн өмч, хөрөнгө, зээл тусламж, хөрөнгө оруулалт



### НИЙГЭМ

Нийгмийн холбоо хамаарал



### ХҮМҮҮН КАПИТАЛ

Ажиллагсад, эрүүл аюулгүй байдал, ёс зүйн зарчим



### БАЙГАЛИЙН НӨӨЦ

Ус, энерги, газар, байгалийн бүтээгдэхүүн



### ҮЙЛДВЭРЛЭЛ

Барилга, үйлдвэрүүд, тоног төхөөрөмж



### ОЮУНЫ КАПИТАЛ

Брэнд, судалгаа хөгжүүлэлт, инноваци, үйл ажиллагаа, компанийн нэр хүнд

## 2018 ОНЫ АПУ ГАРЦ

### САНХҮҮ

**512.9**  
тэрбум төгрөг

Цэвэр борлуулалтын орлого

**48.9**  
тэрбум төгрөг

Нийт зарласан ногдол ашиг

### НИЙГЭМ



“ТунгалагТуул” аян



“Save Life” төсөл

### БАЙГАЛИЙН НӨӨЦ



Саарал ус төсөл  
11 700 тонн



Цахилгааны хэмнэлт  
200 мянган кВт



Нийт ажиллагсад  
2063

Дотоод сургалтын тоо 756



Бүтээгдэхүүний нэр төрөл 260



## БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



### АРХИ, СПИРТИЙН БИЗНЕС НЭГЖ

- Натур Агро спиртийн үйлдвэр нь 2009 онд ашиглалтанд орсон бөгөөд Германы орчин үеийн дэвшилтэт технологи бүхий автомат тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.
- Итали, улсын шилдэг фирмүүдийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютер микропроцессын хяналтын удирдлага бүхий үйлдвэр юм.
- Улаанбаатар спирт ХХК нь 2002 онд ашиглалтанд орсон бөгөөд Германы үйлдвэрлэгч Шмидт компанийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
- Спирт Бал Бурам ХХК нь 1973 онд ашиглалтанд орсон. Хүнсний ууган үйлдвэрүүдийн нэг болох Спирт Бал Бурам ХХК нь 2009 онд хувьчлагдсан бөгөөд архины зах зээлийн хүчтэй тоглогчдын нэг юм.



### ШАР АЙРГИЙН БИЗНЕС НЭГЖ

- Шар айргийн үйлдвэр нь 1927 онд Чех улсын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор сууриа тавьж байсан бол 2002 болон 2013 онуудад Германы Кронес компанийн хамгийн орчин үеийн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн шаардлагыг бүрэн хангасан техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдон бүрэн шинэчлэл хийснээр Германы тэргүүлэх 5 үйлдвэртэй ижил түвшинд хүрсэн томоохон үйлдвэр болсон байна.
- М-Си-Эс Азия Пасифик Брюери ХХК нь 2005 онд ашиглалтанд орсон бөгөөд дэлхийд шар айргийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч компани болох HEINEKEN-ийн чанар, стандартын шаардлагын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг томоохон үйлдвэр юм.



### УС, УНДАА, ШҮҮСНИЙ БИЗНЕС НЭГЖ

- APU Company нь 2004 онд Ус Ундааны үйлдвэрийг бүрмөсөн шинэчлэх анхны төслийн ажлыг хэрэгжүүлэн Европын Холбооны эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан дэлхийн нэртэй фирмүүд болох Австрийн "Клингер", Германы "Косме", "Гернеп", "Фамикс", Италийн "Самса Пак" зэрэг бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
- 2012 онд шинэ ПЭТ савлах шугамын төслийг Герман улсын KRONES компанитай хамтран хэрэгжүүлсэнээр үйлдвэрийн хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлсэн.

## СҮҮНИЙ БИЗНЕС НЭГЖ, АПУ ДЭЙРИ ХХК

Сүүний бизнес нэгж нь 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бие даасан аж ахуйн нэгж болон тусгаарлаж АПУ Дэйри ХХК нэрийн доор малчид, фермерүүдээс сүү цуглуулахаас эхлэн хэрэглэгчдийн гарт хүрэх хүртэлх бүхий л үйл ажиллагааг нэгдсэн байдлаар явуулж эхлээд байна.

Анх 2014 онд сүү боловсруулах тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Герман улсын GEA брэндийн боловсруулах хэсэг Швед улсын Tetra Pak, ЕС-olean, Японы Шюкоку компанийн Elorak, Cup Filler зэрэг савлах машинуудыг суурилуулсан EHEDG буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэр ашиглалтанд орсон түүхтэй. Жилд 45 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай сүүний үйлдвэрийн боловсруулах хэсэг нь өдөрт 150 тонн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай. 2017 онд нэмэлтээр аарц, цөцгийн тос боловсруулан, савлах тоног төхөөрөмжийг суурилуулсанаар Монгол үнээний сүүгээр үйлдвэрлэсэн цэвэр аарц, ааруул, цөцгийн тосыг хэрэглэгчдэдээ шинээр нь хүргэх боломжтой болсон.

АПУ Дэйри ХХК нь сүү бэлтгэн нийлүүлэгчдийн тоо хэмжээ болон сүү бэлтгэдэг бүс нутгийг тасралтгүй өргөжүүлэн ажиллаж байна. 2018 онд 1200 гаруй малчид, фермерүүдээс шууд болон 12 хөргөлтийн цэгээр дамжуулан өдөр бүр сүү татан авч байна.

Мөн бид 2018 онд Монгол улсад анхны кластер ферм байгуулан ажилласан. Улаанбаатар хотоос 95 км зайд тус бүр 40 саалийн үнээтэй өрхүүд нэгдэн, нийт 400 үнээтэй 10 ферм бүхий Монголын анхны сүүний кластер ферм үйл ажиллагаагаа эхлүүлээ. Олон улсын жишигт нийцсэн фермийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад ХААН Банкнаас хөнгөлөлттэй нөхцөл бүхий жижиг дунд бизнесийг дэмжих зээл олгон хамтарч байгаа бол АПУ Дэйри ХХК фермээс бэлтгэгдсэн сүүг тогтвортой үнээр жилийн 4 улирал худалдан авч боловсруулан хэрэглэгчдэд хүргэх, Нүүдэлчин Агро Ферм ХХК нь хөдөө аж ахуйн мэргэжилтэн, бэлтгэн нийлүүлэгчдийг нэгтгэх замаар өртгийн сүлжээг бий болгон хөгжүүлэхээр ийнхүү зорьж байна.

АПУ Дэйри ХХК нь Хүнсний Аюулгүй байдлын Тогтолцооны Баталгаажуулалт - FSSC 22000 (ISO 22000 + ISO 22002+Additional requirement) болон Чанарын Менежментийн Тогтолцоо - ISO 9001 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд жил бүр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажилтын байгууллагаар стандартын хэрэгжилтээ баталгаажуулан, байнгын сайжруулалт хийн амжилттэй ажиллаж байна. Мөн Дотоод хяналтын лаборатори нь анх үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын ISO 17025 стандартыг амжилттай нэвтрүүлж Итгэмжлэгдсэн бөгөөд магадлах, итгэмжлэх аудитыг тухай бүр амжилттай хийлгэж ажиллаж байна.



## ЧАНАРЫН БОДЛОГО



### БИД ЧАНАРЫН БОДЛОГОДОО ДАРААХ 4 ЗАРЧМЫГ БАРИМТЛАНА

- Хууль эрхзүйн болон хэрэглэгчийн шаардлагад бүрэн нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг 100% хангасан, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Хүнсний үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд FSSC22000:2010, ISO 9001:2008 стандартуудын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, байнгын сайжруулалтыг хангана.
- Хүний нөөцийн хөгжил, техник, технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж шингэн хүнс үйлдвэрлэлийн манлайлагч компани болно.
- Хүнсний аюулгүй байдал болон чанарын удирдлагын тогтолцоонд гадаад, дотоод аудитын шалгалт хийх замаар үр дүнг баталгаажуулж ажиллана.

## ЧАНАРЫН УДИРДЛАГА

APU Company нь ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм. Чанарын удирдлага, хяналтын алба нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процессд сорилт, шинжилгээ, туршилт, чанарын хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн байнгын мониторингийн хяналт тавьж ажилладаг.

Бидний бусдаас ялгарах талууд бол:

- Олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлсэн
- Хүнсний аюулгүй байдал, технологийн мэргэшсэн багуудтай
- Чанарын удирдлагын нэгдсэн систем бий болгосон
- Хууль, эрхзүйн нийцлийг бүрэн хангасан
- Процесст суурилсан чанарын мониторингийн хяналтыг бүрдүүлсэн

## ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Итгэмжлэгдсэн лаборатори нь олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүд болон ISO/IEC 17025 стандартыг мөрдлөг болгон APU Company -н үндсэн 5 үйлдвэрлэлд орж буй үндсэн болон туслах түүхий эд материал, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу мэдрэхүй эрхтний, микро биологийн, физик-химийн шинжилгээг үнэн зөв хийж, стандарт шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн гаргахад, технологийн дамжлага бүрт хяналт тавьж ажилладаг. Итгэмжлэгдсэн лабораториуд нь олон улсын сорилтын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO-17025:2007 стандартын шаардлагыг тогтмол хангаж ажилладаг ба Олон Улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, нано технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

Манай лабораториуд нь үйлдвэрлэлдээ дотоод хяналтыг тавихаас гадна үйл ажиллагааныхаа чиглэлээр Герман улсын VLB, Weihenstephan институт, ОХУ-ын Interlab, ФГБНУ ВНИИПБТ институт, Монгол улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиудтай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажилладаг судалгааны томоохон бааз юм.

APU company-н дотоод хяналтын лаборатори нь дараах бодлогыг баримтална

- Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоо болон сорилт шинжилгээний нэгдмэл байдлыг IEC/ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлж, байнгын сайжруулалтаар хангана
- Ажилтан ажиллагсдын хөгжил, техник технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ханган ажиллана
- Болзошгүй санхүүгийн болон бусад хүчин зүйлээс хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулна



## 2018 ОНЫ ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД



СОЁМБО (0.7Л, 39.5%)

**ШИНЭ** “Luxury gift of Mongolia”  
Соёмбо брэндийн дээд  
зэрэглэлийн бэлгийн багц  
2018 онд худалдаанд  
гаргасан.



**САРХАД АЛФА** (0.75Л, 0.5Л, 38%)

**ШИШЭ** “Сархад Альфа” брэнд нь Монгол нутгийн хөрсөнд ургасан шилмэл улаан буудайн тансаг охь АЛФА спиртийг гүний цэнгэг уснаа найруулж олон улсын чанарын стандарт, дэвшилтэт технологийн дагуу үйлдвэрлэсэн цэвэр цагаан САРХАД юм. Тухайн шошгоны өөрчлөлт нь архины онцлог давуу талуудыг бүрэн илтгэж тодотгож гаргаж ирсэн болно



**ХАРАА** (0.75Л, 0.5Л, 38%)

**ШИШЭ** 2018 оны Үндэсний их баяр наадамд зориулан тусгай шошгоны дизайн боловсруулав. Тухайн шошго маань Хараа брэндийн үндсэн SKU болох 750 мл болон 500 мл дээр хийгдсэн



**УЛААНБААТАР** (0.75Л, 0.5Л, 38%)

**ШИШЭ** Анх 1963 онд худалдаанд гарч байсан “Улаанбаатар” архийг нэгдүгээр зэргийн спирт, цэвэр усны найрлагатайгаар кварц чулуун шүүлтүүр ашиглан үхрийн нүдний нэмэлттэй, өвөрмөц амт шингээж 2012 онд шинэчлэн үйлдвэрлэсэн. 2018 онд бүтээгдэхүүний шинэчлэлтийг хийхдээ хэрэглэгчдийн таашаалд нийцүүлэх үүднээс амтыг улам зөөлрүүлж тухайн брэндийн онцлог шинжийг шинэ шошгон дээрээ тодотгож өгсөн болно.



**БОЛОР** (1Л, 0.75Л, 39%)

**ШИШЭ** Шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спиртээр үйлдвэрлэдэг. Болор брэндийн үндсэн төрлийг хайрцагтай багц болгон шинэ жилд зориулан тусгайлан хэрэглэгчдийн гарт хүргэв.

## 2018 ОНЫ ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД

### СЭНГҮР ПЕТ - (2.4 Л)

Азийн ШИЛДЭГ, АЛТАН МЕДАЛЬ-т амт чанараараа хэрэглэгчдэдээ бүрнээ таашаагдсан СЭНГҮР шар айраг нь илүү их хэмжээгээр савлагдан хэрэглэгчиддээ хүрч байна. Амралт зугаалга болон хөдөө авч явахад илүү тохиромжтой 2.4 литрээр савлагдсан, хагарч гэмтэхгүй, зай бага эзлэх зэрэг давуу талтай юм.

ШИНЭ







**НИЙСЛЭЛ – (FIFA LIMITED EDITION)**

**ЭШИЛТ** Их хотын залуусын хэмнэлийг мэдрүүлэгч Нийслэлшарайраг нь 2018 оны Хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд зориулсан лааз төрөл хязгаарлагдмал тоогоор худалдаанд гаргасан билээ.



**КАЛТЕНБЕРГ (0.5Л, 5.5%)**

**ЭШИЛТ** Герман улсын Баварийн вангийн удмын зуун дамжсан туршлагыг шингээсэн улаан буудайн, шүүлтүүргүй шар айраг болох Калтенберг брэндийг 2018 онд шинэчлэн худалдаанд гаргалаа. Тус шар айргийг Баварийн өвөг дээдсээс уламжлагдан ирсэн технологиор үйлдвэрлэдэг бөгөөд 5.5%-ийн спиртийн агууламжтай.



**АЛТАНГОВЬ (5X 450ML 1X БОКАЛ)**

**ЭШИЛТ** Германы уламжлалт цэвэр тунгалаг /Reinheitsgebot/-ийн хуулийн дагуу исгэдэг, тансаг зэрэглэлийн “Алтан Говь” шар айргийг 2003 оноос үйлдвэрлэж эхэлсэн. Сэтгэл тайвшруулах увидас шингээсэн зөрөг цэцгийн хандтай, зөөлөн, амтлаг энэ шар айраг 5.1%-ийн спиртийн агууламжтай.



## 2018 ОНЫ ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД



### ДЭЭЖ МАСЛО

САВЛАГАА: 180Г ТОСЛОГ: 82%

ЭННЭ

“Дээж” цөцгийн тос нь үнээний цэвэр сүүний цөцгийг орчин үеийн техник технологиор боловсруулан үйлдвэрлэсэн өрөм мэт цөцгийн тос юм. Цөцгийн тос нь биологийн идэвхит бодис болох фосфолипид, тосонд уусдаг амин дэмүүд (А, Е, D), бетта каротин, нүүрс ус, эрдсээр баялаг тул хоол хүнсэндээ хэрэглэхэд тохиромжтой.



**САЙН ПЛАС**

САВЛАГАА: АЯГАН, 160ГР ТОСЛОГ: 2,5%

ШИШ

Сайн Плас йогурт нь хүний биед ашигтай пробиотик, эслэгээр баялаг, зохицуулах үйлчилгээтэй онцгой бүтээгдэхүүн юм. Сайн Плас йогурт нь тэжээллэг чанартай тул таны өглөөний болон өдрийн хоолыг орлож чадна. Сайн Плас йогуртанд агуулагдах үр тариа, шинэхэн жимс нь эслэгээр баялаг тул гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг дэмжинэ.



**САЙН ЙОГУРТ \БУУЦАЙ-КИВИ\**

САВЛАГАА: 250ГР ТОСЛОГ 0%

ШИШ

Үнээний сүүг хөрөнгөлж бүрсэн Сайн йогурт нь пробиотик, болон амин дэмээр баялаг бөгөөд дархлааг дэмжинэ. 0% -ийн тослог ба нэмэлт сахар агуулаагүй тул эрүүл мэнддээ анхаардаг, жингээ барьдаг фитнесээр хичээллэдэг хүмүүст түлхүү зориулагдсан.



**САЙН ЙОГУРТ ГИШҮҮНЭ БА ИНТООР**

САВЛАГАА: ЭКОЛИН, 450ГР ТОСЛОГ: 2,5%

ШИШ

100 % үнээний сүүгээр бүрсэн Пробиотикоор баялаг йогурт ууснаар хүний дархлаа дэмжигдэж, хоол боловсруулалт сайжирч, йогуртанд агуулагдаж буй кальци нь яс болон шүдний бат бөх байдлыг хангаж, найрлаганд нь орсон жимс ногоо нь цусан дахь холестеринийг бууруулж, арьсны уян хатан байдлыг нэмэгдүүлж эд эсийн нөхөн төлжилтэнд хурдтай үйлчилдэг.



**САЙН Д ВИТАМИНТАЙ СҮҮ**

САВЛАГАА: ЭКОЛИН, 250ГР ТОСЛОГ: 1,5%

ШИШ

Үнээний шингэн сүүг нам температурт ариутган, D амин дэмээр баяжуулж, олон улсын хүнсний аюулгүй байдлын тогтолцоо ISO 22000 стандартын дагуу үйлдвэрлэн хортой нөхцөлд ажиллаж буй ажилчдад зориулан Хөдөлмөрийн аюулгүй байдалыг хангасан хоргүйжүүлэх үйлчилгээтэй сүү буюу ХАБ-тай сүүг 250 гр Эколин савлагаагаар савлаж байгууллагуудын хэрэгцээнд зориулан нийлүүлж байна. Сайн Д амин дэмтэй сүү нь та бидний өдөрт авах Д амин дэмийн зохистой хэмжээний 125IU буюу, 20% -ийг агуулдаг.

## 2018 ОНЫ НЭГДСЭН БРЭНДҮҮД

### АРХИНЫ БРЭНДҮҮД



**ЧИНГИС ХААН** (0.75л, 40%)

**АРХИ** Анхны ультра супер премиум (дээдийн дээд) зэрэглэлийн энэ цэвэр цагаан архийг зургаан давхар (нүүрс, кварц, очир алмааз, сувд, мөнгө) шүүлтүүрээр гаргаж авсан альфа зэрэглэлийн цэвэр спирт ашиглан гүний цэнгэг усаар үйлдвэрлэсэн. “Чингис Хаан” брэндэд лаванда цэцэг, аньсны үр, буудайн үрний үнэр, амтыг шингээж өгсөн



**СОЁМБО** (1л, 0,75л 39.5%)

**АРХИ** Монгол төрийн бэлгэдэл алтан Соёмбо үсгээр нэрлэгдсэн супер премиум зэрэглэлийн энэ тансаг архийг тусгайлан сонгосон шилмэл улаан буудайн альфа зэрэглэлийн спирт, гүний цэнгэг усыг ашиглаж үйлдвэрлэсэн. “Соёмбо” брэнд нь уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт шүүлтүүр хослуулан, зургаан төрлийн нэмэлт өвөрмөц амт, үнэрийг шингээж гаргасан тансаг зөөлөн амттай архи юм.



**БОЛОР** (1л, 0.75л, 39%)

**АРХИ** Монгол хүн сансарт ниссэн түүхэн үйл явдлыг тохиолдуулан үйлдвэрлэсэн Болор брэндийг 1981 онд зах зээлд анх гаргаж байсан бөгөөд 2008 онд шинэчлэхдээ уламжлалт амт чанарыг шингээж үйлдвэрлэсэн. Шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спиртээр үйлдвэрлэдэг бөгөөд 2011 оноос эхлэн анхилуун жүржний ба цангис жимсний амт шингээж шинэ хоёр төрлийг зах зээлд гаргах болсон.



**ШИНЭ УЛААНБААТАР** (0.75л, 0.5л, 38%)

**АРХИ** Анх 1963 онд худалдаанд гарч байсан “Улаанбаатар” архийг нэгдүгээр зэргийн спирт, цэвэр усны найрлагатайгаар кварц чулуун шүүлтүүр ашиглан үхрийн нүдний нэмэлттэй, өвөрмөц амт шингээж, 2012, 2017 онуудад шинэчлэн хэрэглэгчийн гарт хүргэж байсан бөгөөд 2018 онд брэндийг эрс шинэчилж хэрэглэгчийн таашаалд нийцэхүйц хүчилтөрөгчөөр баяжуулан худалдаанд гаргасан.



**АЛТАН ТҮРҮҮ** (0.75Л, 0.5Л, 38.5%)

**АРХИ** Амт, чанараараа дэлхийд танигдсан Алтантүрүү брэнд нь шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спирт болон цэвэр усны найрлагатай юм.



**ЕРӨӨЛ** (0.75Л, 0.5Л, 0.35Л, 0.1Л, 38%)

**АРХИ** Анхны мөнгөжүүлсэн шүүлтүүртэй “Ерөөл” брэнд 2003 онд худалдаанд гарсан, аньс болон ургамлын хандны онцгой нэмэлт агуулсан сархад юм. Нэгдүгээр зэрэглэлийн спирт, зөөлрүүлсэн усаар уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт шүүлтүүртэй хослуулан үйлдвэрлэдэг.



**АРХИ** (0.75Л, 0.5Л, 0.35Л, 35%, 38%, 39.5%)

**АРХИ** Шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спиртээр 1976 онд экспортод гаргах зорилгоор анх үйлдвэрлэж байсан цэвэр “ARKHI” брэндийг 2011 онд дахин шинэчлэн худалдаанд гаргасан. Уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт шүүлт болох нүүрсэн, элсэн, мембранан болон дөрвөн давхар мөнгөжүүлсэн шүүлтүүртэй хослуулан гаргаж авсан зөөлөн амттай “ARKHI” нь ямар нэгэн нэмэлт орц агуулаагүй цэвэр цагаан архи юм.



**ТАЙГА** (0.75Л, 0.5Л, 35%, 38%, 39%)

**АРХИ** Монгол нутгийн хөрсөнд ургасан ургамал жимсгэний ханд бүхий онцгой найрлагатай 4 улирлын онцлогийг хадгалсан байгалийн гаралтай Тайга архийг хэрэглэгч олондоо бэлэг болгон хүргэсэн.

## АРХИНЫ БРЭНДҮҮД



ЭДЕН (1Л, 0.7Л, 36%)

**АРХИ** Өөрийн гэсэн мэдрэмжээр ертөнцийг хардаг, урлаг уран сайхныг таашааж үздэг, зорилго мөрөөдөлдөө үнэнч хэн бүхэнд зориулан APU Company “Мэдрэмж хөглөх амт” буюу EDEN брэндийг 2016 онд зах зээлд нэвтрүүлсэн.



ВЭЛВЭТ (1Л, 0.7Л, 38%)

**АРХИ** “VELVET” брэнд нь залуусын цагийг зугаатай, хөгжилтэй өнгөрүүлэх тансаг үдшийн хэв маягийн илэрхийлэл бөгөөд энэхүү бүтээгдэхүүнийг шинийг санаачлах хүсэл эрмэлзэлтэй, өөртөө итгэлтэй эрч хүчээр дүүрэн залууст зориулан зах зээлд гаргасан.



ЭВОК (1.75Л, 0.75Л, 39%)

**АРХИ** Бид дэлхийн нэр хүндтэй Heineken-ийн олон улсын багтай хамтран амт чанар, өнгө үзэмжийн хувьд давтагдашгүй Дэлхийд өрсөлдөхүйц тансаг зэрэглэлийн брэндийг Монголдоо үйлдвэрлэхээр 2 жил гаруй хугацаанд шаргуу хөдөлмөрлөсний эцэст 2014 оны 8 сарын 4-нд өөрийн гэсэн хэв маяг, загвар дизайн, амт чанараараа давтагдашгүй EVOK брэнд анхлан Монголын зах зээлд мэндэлсэн.



ЦАГААН ЧИНГИС (0.5Л, 0.75Л, 39%)

**АРХИ** Монголд анх удаа “Milk Filter” буюу сүүн шүүлтүүрийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нэмэлт хүнсний бодис ашиглахгүйгээр, цэвэр сүүгээр архин бүтээгдэхүүний найрлага дахь химийн элементийг шүүж, хоруу чанарыг бууруулдаг тусгай технологийг нэвтрүүлэн, илүү таатай зөөлөн амтыг, өвөрмөц ёс заншил, бахархах түүхтэй Монгол түмнийхээ хэрэгцээнд онцгойлон зориулан бүтээсэн тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн юм.

**ОРИГНАЛЬ ЧИНГИС** (0.5Л, 0.75Л, 39%)

**АРХИ** 40 жилийн арвин туршлагатай “Спирт бал бурам” ХХК-ийн мэргэжилтнүүдийн бүтээсэн хамгийн анхны тансаг зэрэглэлийн брэнд Чингис 2002 онд зах зээлд танилцуулагдаж байсан түүхтэй. Зах зээлд гарсан цагаасаа хойш олон улсын бүхий л нэр хүндтэй тэмцээн уралдаанд амжилттай оролцож хамгийн олон шагналын эзэн болж Монголын нэрийг дэлхийд таниулсан экспортын шилдэг брэнд болж чадсан юм.

**ХАРАА** (0.1Л, 0.2Л, 0.35Л, 0.5Л, 0.75Л, 38%)

**АРХИ** Хараа брэнд анх 1993 онд үүссэн брэнд бөгөөд үүссэн цагаасаа хойш өнгө төрхөө олон удаа шинэчилж, одоо Цэвэр Хараа, Зөөлөн Хараа гэсэн хоёр төрлөөр гарч байна. Цэвэр Хараа брэнд нь уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулсан “Мөнгөжүүлсэн шүүлт”-ээр бүрэн шүүж чадсан дэвшилтэт бүтээгдэхүүн юм. Зөөлөн Хараа брэнд нь илүү зөөлөн амтыг таашаадаг хэрэглэгчиддээ зориулан Алтжуулсан шүүлтийг ашиглан гаргасан онцгой сайн бүтээгдэхүүн болж чадсан.

**САРХАД** (0.5Л, 0.75Л, 38%)

**АРХИ** “Сархад Альфа” брэнд нь Монгол нутгийн хөрсөнд ургасан шилмэл улаан буудайн тансаг охь АЛФА спиртийг гүний цэнгэг уснаа найруулж олон улсын чанарын стандарт, дэвшилтэт технологийн дагуу үйлдвэрлэсэн цэвэр цагаан САРХАД юм. 2018 онд Сархад брэндийг шинэчлэн хэрэглэгчийн гарт хүргэсэн.

**ТИТЭМ** (0.5Л, 0.75Л, 36.5%)

**АРХИ** Шинэ цагийн Монгол лидерүүдийн сонголтод зориулж бид ТИТЭМ брэндийг бүтээв. Энэхүү брэнд маань бидний 70 жилийн арвин их туршлага, Монгол орны үржил шимт хөрсөнд ургасан цэвэр улаан буудайн тансаг охь альфа спиртийн төгс хослол юм. ТИТЭМ-ийг бид давхар платинум шүүлтүүрээр шүүж Монголд цор ганц буй дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи - давхар хамгаалалт бүхий 2В ухаалаг бөглөөгөөр битүүмжиллээ. ТИТЭМ брэндийн хатуулаг 36.5% байгаа нь хэрэглэгчид брэндийн сэтгэл сэргээм, торгон зөөлөн амтыг мэдрэхэд хамгийн төгс хэм гэж олон жилийн арвин туршлагатай мэргэжилтнүүд тодорхойлсон.

## ШАР АЙРГИЙН БРЭНДҮҮД



**HEINEKEN** (0.33Л, 0.45Л, 0.5Л, 5.0%)

**ШАР АЙРАГ** Heineken – Дэлхийн 192 оронд танигдсан, тэргүүлэгч олон улсын дээд зэрэглэлийн шар айраг. Амстердам хотод анх үүсэн Жерард Адриан Хайнекен хэмээх үүсгэн байгуулагчийн нэрээр нэрлэгдсэн дээд зэрэглэлийн Heineken® брэнд нь 192 гаруй оронд борлуулагдаж байна. Чанар бол Heineken® брэндийн хамгийн чухал үзүүлэлт бөгөөд уламжлалт технологийн дагуу исгэсэн өөрийн нэрийн “А” хөрөнгийг ашиглан үйлдвэрлэдэг. Heineken® брэнд нь дэлхийд алдартай олон улсын хөгжим, кино, спортын арга хэмжээг дэмжин ажилладагаараа онцлог юм.



**ТАЙГЕР** (0.33Л, 0.5Л, 5%)

**ШАР АЙРАГ** 1932 онд үйлдвэрлэж эхэлсэн Tiger шар айраг исгэлтийн онцгой технологи, амт чанараараа шалгарч, өдгөө дэлхийн 70 гаруй орны сая сая хэрэглэгчдийн дуртай брэнд болоод байна. Tiger шар айргийг 200 гаруй чанарын шалгалтын дор 500 гаруй цаг исгэдэг бөгөөд олон улсын нэр хүндтэй 40 гаруй шагналыг хүртсэн. Tiger нь Монгол улсад үйлдвэрлэгдэж хэрэглэгчдэд шинэхэнээрээ хүрдэг анхны, олон улсын, дээд зэрэглэлийн шар айраг бөгөөд ийм ч утгаараа Монголын хэрэглэгчдийн хувьд онцгой бүтээгдэхүүн юм.



**КАЛТЕНБЕРГ HEFEWEISBIER** (0.5Л, 5.5%)

**ШАР АЙРАГ** APU Company Герман улсын Баварийн вангийн удмын зуун дамжсан туршлагыг шингээсэн улаан буудайн, шүүлтүүргүй шар айргийг Монголд анх удаа худалдаанд гаргаж байна. “Цэвэр Тунгалагийн Хууль”-ийн дагуу Калтенбергийн өвөрмөц хөрөнгөөс үүдэн бүүдгэр харагддаг энэхүү улаан буудайн сонгодог шар айргийг үйлдвэрлэхэд хамгийн сайн чанарын түүхийг эдийг ашигладаг. Амтат зөрөг цэцэг болон гадил жимсний өвөрмөц амттай энэхүү шар айргийг Баварийн өвөг дээдсээс уламжлагдан ирсэн технологиор үйлдвэрлэх бөгөөд 5.5%-ийн спиртийн агууламжтай.



**КАЛТЕНБЕРГ SPEZIAL** (0.5Л, 5.6%)

**ШАР АЙРАГ** Баварийн Хаадын удмын Калтенберг брэндийн шинэ гишүүн, Бавари мужийн баярын онцгой шар айраг болох Калтенберг Специал брэндийг 2017 онд Монголын зах зээлд нэвтрүүлсэн. Баварийн “Цэвэр Тунгалагийн Хууль”-ийн дагуу исгэсэн уг пиво нь Бавари мужийн Халлертау нутгийн сайн чанарын онцгой зөрөг цэцэг, дээд зэргийн арвайн соёлж, Калтенбергийн шалгарсан хөрөнгөөр исгэсэн шүүлтүүртэй цайвар пиво юм.





**АЛТАН ГОВЬ** (0.33Л, 0.45Л, 0.5Л, 5Л, 5.1%)

**ШАР АЙРАГ** Германы уламжлалт “Цэвэр Тунгалагийн Хууль”-ийн дагуу исгэдэг, тансаг зэрэглэлийн “Алтан Говь” шар айргийг 2003 оноос үйлдвэрлэж эхэлсэн. Сэтгэл тайвшруулах увидас шингээсэн зөрөг цэцгийн хандтай, зөөлөн, амтлаг энэ шар айраг 5.1%-ийн спиртийн агууламжтай.



**НИЙСЛЭЛ** (0.45Л, 0.5Л, 2.5Л, 5%)

**ШАР АЙРАГ** Зөв, соёлтой хэрэглээний илэрхийлэл болсон “Нийслэл” шар айргийг 1972 оноос үйлдвэрлэж эхэлжээ. Монголын ууган шар айргийн нэг “Нийслэл” брэндийг Герман технологиор шинэчилж, 5.0%-ийн спиртийн агууламжтайгаар савалгааны өргөн сонголттой үйлдвэрлэж байна.



**БОРГИО** (0.45Л, 0.5Л, 2.5Л, 5.5%)

**ШАР АЙРАГ** Үлэмжийн чанар, монголын бахархал “Боргио” шар айргийг 1927 онд анх үйлдвэрлэжээ. Экспортод гаргаж байсан анхны шар айраг “Боргио”-г Германы дэвшилтэт технологиор шинэчлэж, 5.5%-ийн спиртийн агууламжтайгаар, савалгааны өргөн сонголттой үйлдвэрлэж байна.



**СЭРҮҮН** (0.45Л, 0.5Л, 2.5Л, 4.8%)

**ШАР АЙРАГ** Жинхэнэ LIGHT шар айраг “СЭРҮҮН” брэндийг шар айргийн дэвшилтэт технологи СЭРҮҮН шүүлтийн системийг ашиглан, шинэ үеийн хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлэлд нийцүүлэн үйлдвэрлэлээ. 90 жилийн туршлага, шинэ үеийн шинэчлэлийг агуулсан “СЭРҮҮН” брэнд нь 4.8%-ийн спиртийн агууламжтайгаар савлагааны өргөн сонголттой үйлдвэрлэгдэж байна.

## ШАР АЙРГИЙН БРЭНДҮҮД



**СЭНГҮР** (0.45Л, 0.5Л, 2.4Л, 30Л, 4.8%)

**ШАР АЙРАГ** Герман Брюмастерын ууган бүтээл, үндэсний брэнд Сэнгүр нь анх 2007 онд зах зээлд худалдаалагдаж эхэлсэн. Сэнгүр нь 2014 онд Дэлхийн шилдэг шар айргыг тодруулдаг “WORLD BEER AWARDS 2014” –с амт чанараараа шалгарч АЗИЙН ШИЛДЭГ ШАР АЙРАГ & АЛТАН МЕДАЛ хүртэж дэлхийн брэндүүдтэй өрсөлдөхүйц шар айраг гэдгээ олон улсад баталлаа. СЭНГҮР брэнд нь үргэлж шинэлэг, шинэ мэдрэмжийг хэрэглэгчдэдээ өгөхийг зорьдог юм.



**СЭНГҮР WHITE** (0.45Л, 0.5Л, 2.4Л, 30Л, 4.8%)

**ШАР АЙРАГ** Улаан буудайн шар айраг нь Герман, Бельги улсаас гаралтай бөгөөд энэ төрлийн шар айргийг “White beer” буюу Цагаан шар айраг хэмээн нэрлэдэг. СЭНГҮР WHITE нь шүүлтүүргүй мэт бүүдгэр өнгөтэй, энгийн шар айргаас илүү өтгөн, жүржийн өвөрмөц амттай юм.



**СЭНГҮР RADLER** (0.45Л, 0.5Л, 1.9%)

**ШАР АЙРАГ** Радлэр гэдэг нь Германаар дугуйчин гэсэн утгатай үг юм. 1922 онд Германы Мюнхен хотын нэгэн паб-д 13000 дугуйчин зэрэг хүрэлцэн ирсэн ба пабд байсан шар айргийн нөөц хүрэхгүй байсан учир нимбэгний шүүстэй хольж өгсөн нь радлэр хэмээх шинэ төрөл үүсэх эхлэлийг тавьсан гэдэг. Арвайн соёолж, зөрөг цэцгийг цэнгэг уснаа хандлан исгэж, натурал НИМБЭГ жимсний жүүсээр баяжуулан үйлвэрлэсэн СЭНГҮР РАДЛЕР нь 1.9% алкохолын агууламжтай, Монголд үйлдвэрлэсэн анхны радлэр шар айраг бөгөөд давхар сэргээх онцгой мэдрэмжийг өгдөгөөрөө онцлогтой.



**LEGEND** (0.45Л, 0.5Л, 5.2%)

**ШАР АЙРАГ** “Legend – Монголын анхны Heineken стандартаар исгэгдсэн, олон улсын чанарын шаардлага хангасан Премиум зэрэглэлийн шар айраг. Дээд зэрэглэлийн арвайн цайвар болон хар соёолж, зөрөг цэцгийг цэнгэг уснаа хандлан сонгомол хөрөнгөөр исгэж, шар айргийн салбарт 150 жилийн түүхтэй, дэлхийн №1 дээд зэргийн шар айраг үйлдвэрлэгч Heineken группын чанар стандартаар баталгаажсан.

## УС, УНДАА, СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БРЭНДҮҮД



**ОРГИЛУУН (0.5Л, 1Л), ОРГИЛУУН КЛАССИК, ЛИМОН ОЙН ЖИМС, БЭРСҮҮТ ЖҮРЖ, ТАРВАС (0.33Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Монголын анхны хийжүүлсэн ус Оргилуун бол эх орны цэвэр тунгалаг усаар хүний өдөр тутмын хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн юм. Уг хийжүүлсэн ус нь хүний биеийн шингэнийг нөхөх чанараараа эрүүл мэндэд онцгой ач тустай төдийгүй кальцийн ион, сульфат ион, хлорын ион, калийн ион, магнийн ион зэрэг нэгдлүүдийг агуулдаг тул хүний биеийн эрдсийн агууламжийг нөхөх үнэт чанартай.



**ЦЭВЭР УС (0.33Л, 0.5Л, 1.5Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

АПУ Цэвэр ус нь 157 метрийн гүнээс гарган авч, 6 давхар шүүлтүүрээр шүүж савласан бүтээгдэхүүн бөгөөд анх 2004 онд үйлдвэрлэсэн Монголын анхны савласан цэвэр ус билээ.



**ТЭРЭЛЖ (1.5Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Бие, сэтгэлийг сэргээх үйлчилгээтэй алтан гагнуур, ганга өвс, цээний үндэс зэрэг зөвхөн байгалийн гаралтай түүхий эдийн хандыг агуулсан онцгой амт, анхилуун үнэр, тусгай найрлагаараа бусдаас ялгардаг “Тэрэлж” хийжүүлсэн ундаа нь хоол боловсруулах эрхтэн, бөөрний үйл ажиллагааг сайжруулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн юм. Энэ бүтээгдэхүүнийг 1981 оноос эхэлж үйлдвэрлэсэн.



**СЭЛЭНГЭ (1.5Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Амьсгалын зам болон цусны эргэлтийг сайжруулах, бие махбодийг сэргээх үйлчилгээтэй “Сэлэнгэ” хийжүүлсэн ундаа нь нохойн хошуу, ганга өвс, чихэр өвс, шилмүүс зэрэг анхилуун үнэртэй, сэргээх үйлчилгээтэй байгалийн гаралтай түүхий эдийг агуулсан бүтээгдэхүүн юм. Цэвэр байгалийн гаралтай, химийн найрлага ороогүй “Сэлэнгэ” брэндийг 1981 онд анх худалдаанд гаргасан.

## УС, УНДАА, СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БРЭНДҮҮД



**ФРУТТА ЖҮРЖ, АЛИМ, ОЛОН ЖИМСТ (1Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Германы технологи ашиглаж, эх нутгийн гүнийн цэнгэг ус, Европын байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн “Фрутта” брэнд нь сэтгэл сэргээх бүтээгдэхүүн юм. Эрүүл хүнсний олон улсын стандартад нийцсэн, бүх насны хүмүүст зориулсан “Фрутта” ундаа, жимсний шүүсийг 2009 оноос үйлдвэрлэж байна.



**ЦЭВЭР СҮҮ (1Л)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Шинэ Зеландын дээд зэргийн чанартай хатаамал сүүг сэргээн, орчин үеийн шилдэг технологи болох хэт өндөр температураар ариутгаж, олон улсын чанар, эрүүл ахуйн ISO 22000 стандартын дагуу үйлдвэрлэсэн “Цэвэр сүү”-г худалдалт даах Тетра Пак савлагаатайгаар 2006 онд худалдаанд гаргасан. “Цэвэр сүү” нь цөцгий мэт өтгөн, тэжээллэг бөгөөд хүний биед шаардлагатай амин дэм, эрдэс бодисуудаар баялаг, дахин боловсруулахгүйгээр шууд ууж хэрэглэж болох бүтээгдэхүүн юм.



**ДЭЭЖ СҮҮ, ДЭЭЖ ТАРАГ, ДЭЭЖ ТАРАГ БОР САХАРТАЙ (1Л) ДЭЭЖ ААРУУЛ (400Г, 900Г)**

УС, УНДАА, СҮҮ  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Хэрэглэхэд эвтэйхэн, өргөн амсар бүхий пюрпак савлагаанд савлагдсан үнээний цэвэр сүү, тослог багатай тарагийг “Дээж” нэрийн дор үйлдвэрлэж байна. АПУ компанийн ажилтан, албан хаагчид сэтгэл зүрх, ур ухаанаа шингээн хэрэглэгч олондоо бүтээгдэхүүнийхээ дээдийг өргөн барьдгийг илэрхийлсэн “Дээж” брэнд 2015 оны 10-р сард худалдаанд гарсан юм. Дээж ааруул жимстэй болон энгийн гэсэн 2 төрлөөр худалдаанд гаргасан. Агаар нэвтрүүлэх болон дахин ашиглах түгжээтэй уутан төрлийн савлагаанд савлаж гаргасан нь хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болсон.



УС УНДАА, СҮҮ  
СҮНН БҮТЭЭГДЭХҮҮН

**САЙН ЙОГУРТ ГҮЗЭЭЛЗГЭНЭ 15%, САЙН ЙОГУРТ ОЙН ЖИМС 15%, САЙН ЙОГУРТ ХАД (0.45Л), САЙН ЙОГУРТ ГҮЗЭЭЛЗГЭНЭ, САЙН ЙОГУРТ ОЙН ЖИМС, САЙН ЙОГУРТ ХАД (0.15Л), САЙН БИФИДО ТАРАГ 2.5% (0.9Л), САЙНЗӨӨХИЙ (0.35Л, 0.45Л), САЙН Д-ТЭЙ СҮҮ (0.5Л), САЙН ЙОГУРТ ҮЛУУВАН- ЖҮРЖ, САЙН ЙОГУРТ ҮХҮРЭН МАНЖИН-АЛИМ**

Дэлхийн дэвшилтэт технологи ашиглан, олон улсын стандартад нийцсэн шинэ өнгө, төрх, амт чанартай, байгальд ээлтэй савлагаа бүхий “Сайн” брэндийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг олон нэр төрлөөр үйлдвэрлэж байна. Монгол үнээний шингэн сүүг боловсруулж гаргаж авсан, эрүүл хүнсний олон улсын стандартад нийцсэн эдгээр бүтээгдэхүүн нь нэр төрөл тус бүрийн онцлогоос хамааран амин дэм, эрдэс бодисуудаар баялаг байдаг.



**МААМУ ЖҮҮС НОГООН АЛИМ, ОЛОН ЖИМСТ ЧАЦАРГАНА, АНЬС (0.2Л)**



УС УНДАА, СҮҮ  
СҮНН БҮТЭЭГДЭХҮҮН

**МААМУ ГҮЗЭЭЛЗГЭНЭТЭЙ СҮҮ, МААМУ БАНАНАТАЙ СҮҮ, МААМУ ШКОЛАДТАЙ СҮҮ (0.125Л), МААМУ ЙОГУРТ НЭРС 30%, МААМУ ЙОГУРТ ТООР 30%, МААМУ ЙОГУРТ ГҮЗЭЭЛЗГЭНЭ 30% (0.2Л)**

Монгол орны хөрсөнд ургасан байгалийн аньс чацарганатай Маамууг Эрүүл Монгол хүүхдийн өдөр тутмын хэрэглээнд зориулан гаргалаа. А, С, В1, В2 аминдэм кали, кальци, магни, төмөр, иод зэргийг агуулсан нь биеийн эсэргүүцлийг дэмжих онцгой нөлөөтэй. Худалдаанд гарснаас хойш бяцхан хэрэглэгчдийн дуртай бүтээгдэхүүний нэг болсон билээ.

## ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД





## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: АПУ

Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: 1

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 5682<sup>1</sup>

Компанийн эрх барих дээд удирдлага: Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

ХЭХ-ын чөлөөт цагт компанийг удирдах этгээд: Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

Гүйцэтгэх удирдлага: Гүйцэтгэх захирал (Хувь хүн)

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ<sup>2</sup>:



## ОХИН КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ:

1. Сингапур Улсад бүртгэлтэй - Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд (Mongolian Beverages Company Pte.Ltd)
2. Монгол Улсад бүртгэлтэй - Спирт бал бурам ХХК
3. Монгол Улсад бүртгэлтэй - СББ Трейд ХХК
4. Монгол Улсад бүртгэлтэй - М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК
5. Монгол Улсад бүртгэлтэй - АПУ Трейдинг ХХК
6. Монгол Улсад бүртгэлтэй - Депод ХХК
7. Монгол Улсад бүртгэлтэй - Улаанбаатар спирт ХХК
8. Монгол Улсад бүртгэлтэй - Натур агро ХХК
9. Монгол Улсад бүртгэлтэй - АПУ Дэйри ХХК
10. Оросын Холбооны Улсад бүртгэлтэй - Гранд ХХК
11. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад бүртгэлтэй - Чингис хаан Интернэшнл Лимитэд

<sup>1</sup>ҮЦТХТ ХХК-аас 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болж гаргасан Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааны мэдээлэл

<sup>2</sup>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Голомт банк ХХК нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээр бүртгэлтэй байсан бөгөөд тус өдөр Голомт банк ХХК өөрийн эзэмшлийн хувьцаанаас 117,175,348 ширхэг хувьцааг багцын арилжаагаар Steppe Beverage KFT-д худалдсанаар хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд өөрчлөлт орсон.



# НЭГДЛИЙН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

---

- АПУ ХК ба Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хооронд байгуулагдсан Нэгтгэх гэрээний дагуу АПУ ХК дараах охин компаниудын хувьцаа эзэмшигчээр улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо:

2018.01.18 – АПУ Трейдинг ХХК  
 2018.01.25 – М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК  
 2018.01.22 – Улаанбаатар спирт ХХК  
 2018.01.30 – Натур агро ХХК  
 2018.05.02 – Сингапур Улсад бүртгэлтэй Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд

---

- Толгой компанийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг охин компаниудын Гүйцэтгэх захирлаар томилогдсоныг улсын бүртгэлд бүртгэсэн огноо:

2018.01.18 – АПУ Трейдинг ХХК  
 2018.01.22 – Спирт бал бурам ХХК  
 2018.01.22 – СББ Трейд ХХК  
 2018.01.24 – Дөпөд ХХК  
 2018.01.25 – М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК  
 2018.01.30 – Натур агро ХХК

---

- 2018.01.25: АПУ ХК-ийн энгийн хувьцааны 25%-ийг эзэмшигч Хайнекен Азия Пасифик Пте.Лтд-ийн шаардлагаар АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдаж, ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг сонгосон.

1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. С.Громов
4. Кеннет Чу
5. Яспер Хамакер
6. Г.Ганболд
7. Ө.Батбаяр (хараат бус гишүүн)
8. Ё.Гэрэлчулуун (хараат бус гишүүн)
9. Ж.Үнэнбат (хараат бус гишүүн)

---

- 2018.01.25: АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар “Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичиг”-ийг хуульд нийцүүлэн боловсруулж, батлах эрхийг ТУЗ-д олгохоор шийдвэрлэсэн.

# 2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Засаглалын сайжруулалт: Эрх мэдлийн хуваарилалтын шинэчлэл
- Компанийн Дүрмийн өөрчлөлт
- Охин компанийн өөрчлөн байгуулалт
- Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт

## ЗАСАГЛАЛЫН САЙЖРУУЛАЛТ: ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

2018 оны 01 дүгээр сарын 25-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас эрх олгосны үндсэн дээр 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр “Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичиг”-ийг баталж, ТУЗ ба Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалын шилдэг туршлагад нийцүүлэн шинэчлэн тогтоосон.

## ОХИН КОМПАНИЙН ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ

Сингапурт бүртгэлтэй Монголиан Бэвэрэйжс Компани Пте. Лтд-ийг татан буулгахаар шийдвэрлэв.

- 2018.09.25-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч АПУ ХК-ийн ТУЗ-ийн хурлаас тус компанийг татан буулгах шийдвэр гарсан.
- Татан буулгагчаар Сингапурын хуульч Farooq Mann-ыг томиллов.
- Татан буулгах ажиллагаа үргэлжилж байна.

Депод ХХК-ийг татан буулгахаар шийдвэрлэв.

- 2018.12.07-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч АПУ ХК-ийн ТУЗ-ийн хурлаас Депод ХХК-ийг татан буулгах шийдвэр гарсан.
- 2019.02.25-ны өдөр Депод ХХК татан буугдав.

Улаанбаатар спирт ХХК-ийг татан буулгахаар шийдвэрлэв.

- 2018.12.07-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч АПУ ХК-ийн ТУЗ-ийн хурлаас Улаанбаатар спирт ХХК-ийг татан буулгах шийдвэр гарсан.
- Татан буулгах ажиллагаа үргэлжилж байна.

## КОМПАНИЙН ДҮРМИЙН ӨӨРЧЛӨЛТ

2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр компанийн Дүрэмд компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулж, Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн агуулга:

- Үйл ажиллагааны чиглэлийг улсын бүртгэлийн журмын дагуу томьёолсон;
- Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичгийн дагуу ТУЗ-ийн бүрэн эрх, Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн талаарх Дүрмийн зүйл, заалтуудад өөрчлөлт орсон.

## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох Голомт банк ХХК нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өөрийн эзэмшлийн 117,175,348 ширхэг хувьцааг багцын арилжаагаар Унгар Улсад бүртгэлтэй Steppe Beverage KFT-д худалдсан байна.

Улмаар компанийн 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд өөрчлөлт орсон.

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН СТАТИСТИК (2012-2018 ОН):

Он	Төрөл	Огноо	Ирц	Биеэр оролцсон (бүртгүүлсэн) хувьцаа эзэмшигчдийн тоо
2012 он	Ээлжит	2012.03.29	93.29%	132
2013 он	Ээлжит	2013.04.26	93.10%	160
2014 он	Ээлжит	2014.04.28	93.33%	178
2015 он	Ээлжит	2015.04.29	94.19%	180
2016 он	Ээлжит	2016.04.22	94.10%	187
2017 он	Ээлжит	2017.03.31	93.79%	198
	Ээлжит бус	2017.08.18	95.16%	109
2018 он	<b>Ээлжит бус</b>	<b>2018.01.25</b>	<b>94.97%</b>	<b>227</b>
	Ээлжит	<b>2018.04.20</b>	<b>95.94%</b>	<b>435</b>

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:



**Пүрэвийн Батсайхан**  
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд  
ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн  
Ерөнхийлөгч  
Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга  
2002 оноос хойш АПУ ХК-ийн  
ТУЗ-ийн дарга



**Кеннет Чу**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик  
компанийн Гүйцэтгэх захирал  
2018 оноос хойш АПУ ХК-ийн  
ТУЗ-ийн гишүүн



**Яспер Хамакер**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен компанийн Бүс  
нутгийн санхүү хариуцсан  
тэргүүн захирал  
2018 оноос хойш АПУ ХК-ийн  
ТУЗ-ийн гишүүн



**Бүрэнтогтохын Батбаяр**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү  
эрхэлсэн захирал  
2013 оноос хойш АПУ  
компанийн ТУЗ-ийн гишүүн



**Сергей Громов**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал компанийн  
ТУЗ-ийн дарга  
2013 оноос хойш АПУ ХК-ийн  
ТУЗ-ийн гишүүн



**Галсангийн Ганболд**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Голомт банкны Ерөнхийлөгч  
2017 оноос хойш АПУ ХК-ийн  
ТУЗ-ийн гишүүн



**Өлзийдэлгэрийн Батбаяр**  
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
 Баттур Трейвэл ХХК, Улаанбуудайн  
 эх газар ХХК-ийн Ерөнхий захирал  
 Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн  
 дарга  
 2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
 ийн гишүүн



**Жигжидийн Үнэнбат**  
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
 Монголын Банкны Холбооны  
 Гүйцэтгэх захирал, Ерөнхий  
 нарийн бичгийн дарга  
 2013 оноос хойш АПУ ХК-ийн  
 ТУЗ-ийн гишүүн



**Ёндон-Ойдовын Гэрэлчулуун**  
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
 Нээлттэй хот ТББ-ын үүсгэн  
 байгуулагч  
 2017 оноос хойш АПУ ХК-ийн  
 ТУЗ-ийн гишүүн



**Чадраабалын Ариунсан**  
**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН:

### I) Аудитын хороо:

1. Ж.Үнэнбат (Хорооны дарга, хараат бус гишүүн)
2. Яспер Хамакер
3. Ө.Батбаяр (хараат бус гишүүн)

### II) Нэр дэвшүүлэх хороо:

1. П.Батсайхан (Хорооны дарга)
2. Ө.Батбаяр (хараат бус гишүүн)
3. Ё.Гэрэлчулуун (хараат бус гишүүн)


### III) Цалин урамшууллын хороо:

1. Ё.Гэрэлчулуун (Хорооны дарга, хараат бус гишүүн)
2. Үнэнбат (хараат бус гишүүн)
3. Кеннет Чу

## 2018 ОНЫ ТУЗ-ИЙН ХУРЛЫН СТАТИСТИК:

Огноо	Төрөл			Хэлбэр		Баталсан тогтоолын тоо
	Ээлжит	Ээлжит бус	Хуралдаан	Эчнээ санал хураалт	Ирц	
2018.01.24		*		*	100%	1
2018.01.25		*	*		89%	3
2018.02.19		*		*	100%	1
2018.02.21	*		*		89%	3
2018.03.09		*		*	100%	1
2018.04.25		*		*	100%	2
2018.05.24	*		*		89%	1
2018.09.25	*		*		78%	3
2018.11.05		*		*	100%	2
2018.12.07	*		*		89%	5
2018.12.31		*		*	100%	1
<b>Нийт</b>	<b>4</b>	<b>7</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>94%</b>	<b>23</b>


### ТУЗ-ИЙН ХУРАЛ БОЛОН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТАД ТУЗ-ИЙН ГИШҮҮН ТУС БҮРИЙН ОРОЛЦСОН БАЙДАЛ:



\*2018.01.25-ны ХЭХ-аар шинэ ТУЗ сонгохоос өмнөх бүрэлдэхүүн

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


АПУ ХК-ИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 2018 ОНЫ ЭЦСИЙН БАЙДЛААР 662 ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙНА. ЖИЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЛИЙГ ГРАФИКААР ҮЗҮҮЛЭВ:



СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Он	Нийт арилжигдсан ширхэг	Нийт үнийн дүн	Жигнэсэн дундаж ханш
2014	189,096	720,112,356	3,808
2015	265,511	950,068,436	3,578
2016H1	461,038	1,636,041,036	3,668
2016H2*	1,685,624	669,960,016	401
2017	19,366,443	12,268,745,065	634
2018	130,065,842	92,375,598,444	710

\* Компанийн нэгж хувьцааг 2016 оны 6-р сарын 20-ны өдөр 10 дахин хуваав.



■ Арилжигдсан ширхэг (мянга)  
 ■ Арилжааны нийт үнийн дүн (сая төг)  
 — Жинлэсэн дундаж ханш (төг)



■ Арилжигдсан ширхэг (сая)  
 ■ Арилжааны нийт үнийн дүн (тэрбум төг)  
 — Жинлэсэн дундаж ханш (төг)




## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2018 онд нэгж хувьцаанд 46 төгрөг буюу нийт 49 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн билээ.

Ногдол ашгийн төлбөрийг компанийн нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

### Ногдол ашгийн хуваарилалт



Он	Нийт хувьцааны тоо (ширхэг)	Халаасны хувьцааны тоо (ширхэг)	Нийт ногдол ашиг тараах хувьцааны тоо (ширхэг)	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг)	Нийт зарласан ногдол ашиг (төгрөг)
2012 он	74,287,700	120,681	74,167,019	70	5,191,691,330
2013 он	74,287,700	120,681	74,167,019	90	6,675,031,710
2014 он	74,287,700	120,681	74,167,019	-	-
2015 он	74,287,700	120,681	74,167,019	70	5,191,691,330
2016 он*	742,877,000	1,206,810	741,670,190	1	741,670,190
2017 он	1,064,181,553	1,206,810	1,062,974,743	10	10,629,747,430
2018 он	1,064,181,553	1,206,810	1,062,974,743	46	48,896,838,178

\* Компанийн нэгж хувьцааг 2016 оны 6-р сарын 20-ны өдөр 10 дахин хуваав.



## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

1 | ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ  
Гүйцэтгэх захирал

2 | АРИУНАА ДАНДАРОВА  
Маркетинг эрхэлсэн захирал

3 | ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ  
Санхүү эрхэлсэн захирал

4 | БАТСАЙХАНЫ ГАНТИГ  
Стратеги эрхэлсэн захирал



10

8

9

2

5

**5 ХОУ ТЭЙК ПЭН**  
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал

**8 ЦООДОЛЫН ЭРДЭНЭЖАРГАЛ**  
Экспорт эрхэлсэн захирал

**6 ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ**  
Борлуулалт эрхэлсэн захирал

**9 САНЖИЙН ГАНЗОРИГ**  
АПУ Дэйри ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

**7 ШИПИЛОВЫН ДӨЛГӨӨН**  
Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал


**10 БАТХҮРЭЛИЙН ЧИНТОГТОХ**  
Спирт Бал Бурам ХХК-ийн  
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Үр ашигтай эрсдэлийн удирдлага нь APU Company стратеги, үйл ажиллагааны зорилгодоо хүрэхэд зайлшгүй шаардлагатай, бизнесийн салшгүй хэсэг бөгөөд компанийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэн ажиллахад эрсдэлийн удирдлагын бодлого, зарчим чухал нөлөөтэй юм. Өнгөрсөн жилүүдэд хийгдсэн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлууд, тэр дундаа шингэн хүнсний салбарт Дэлхийд тэргүүлэгч, HEINEKEN компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласны үр дүнд APU Company нь олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, компанийн стратеги болон өдөр тутмын үйл ажиллагаанаас бий болж буй гол эрсдэл болон боломжуудыг удирдан ажиллаж байна.

2018 онд бид компанийн бизнесийн нэгдэл, нийлэлттэй холбоотой учирч болох эрсдэлийг тусгайлан авч үзсэн ба боломжит үр дагаврыг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг боловсруулж, компанийн эрсдэлийн аппетитийн хүрээнд удирдан ажиллах боломжтой эрсдэлүүдийн магадлал/давтамж болон нөлөөллийг зохих түвшин хүртэл сулруулах/бууруулах, эрсдэлийг сулруулахад чиглэсэн кампанит ажлуудыг тогтмол зохион байгуулах зэргээр үр дүнтэй ажиллалаа.





# ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



ХОУ ТЭЙК ПЭН “Үйлдвэрлэл, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал”

## ДЭЛХИЙ НИЙТИЙН ХАНДЛАГА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ РҮҮ ЧИГЛЭЖ БАЙНА

Та манай уншигчдад өөрийгөө товч танилцуулна уу.

Уншигчдадаа энэ ярилцлага хүрэх өдрийн мэнд хүргэе. Намайг Даниел Хоу гэдэг. Миний бие Сингапур улсын иргэн, инженер мэргэжилтэй. Их сургуулиа төгссөнөөс хойш 32 жил тасралтгүй олон салбарт ажиллаж байна. Сүүлийн 23 жилийн турш Камбож, Мьянмар, Папуа Шинэ Гвиней, Сингапур болон Филиппин зэрэг улсын шар айраг үйлдвэрлэлийн салбарт ажиллаж ирсэн. APU Company-д Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар ажиллаж байгаа туршлага маань хамгийн их сорилт дагуулсан гэж хэлж болно. Хэдий тийм ч би гайхалтай баг, хамт олонтойгоо хамтарч ажилладагтаа туйлын таатай байгаа.

Таны бодлоор компанийн хувьд бизнесийн өсөлт болон тогтвортой хөгжил зэрэгцэн орших боломжтой юу?

Энэ асуултыг өөр үгээр “Байгаль орчноо сүйтгэхгүйгээр эдийн засаг хөгжих боломжтой юу?” гэж хэлж болох байх. Миний бодлоор боломжтой. Тогтвортой хөгжлийг хангахын тулд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөө багасгах оролдлого гаргахын сацуу бизнесийн өсөлттэй яваа Европын олон компанийн жишээ бий. Тэдгээрийн нэг нь Хайнекен компани бөгөөд тогтвортой хөгжлийг хангах бизнесийн тэргүүн зорилтын нэг болгож ‘Brewing a better world’ (Сайхан дэлхийг цогцлооё) хэмээх санаачилгыг анхлан хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү санаачилгын хүрээнд ус болон эрчим хүчний хэмнэлт, CO<sub>2</sub>-ын ялгарлыг бууруулах зэрэг ажил хийгддэг. Дэлхий нийтийн хандлага тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэж байна. Аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч байгаль орчинд ээлтэй эсэхээс шалтгаалан сонголтоо хийх хэрэглэгч олширч байна. Тиймээс APU Company Байгаль орчны тогтвортой хөгжлийн стратегийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Та бидэнд APU Company байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар ямар арга хэмжээ аван ажиллаж байгааг ярьж өгнө үү?

APU Company сүүлийн жилүүдэд усны хэрэглээг багасгах, саарал усыг цэвэрлэгээ, усалгаанд дахин ашиглах зэрэг байгаль орчны нөлөөллөө багасгахад чиглэсэн ажлуудаа эрчимжүүлсээр ирсэн. Монгол улс цэвэр усны нөөц хомс орнуудын тоонд багтдаг ба 20 жилийн дотор цэвэр усны хомсдолд орно гэсэн судалгаанууд байдаг. Дусал бүр үнэтэй! Бид үйлдвэрлэлийн явцдаа усны хэрэглээг хязгаарлах дорвитой алхмуудыг хийн ажиллаж байна.

APU Company Zero Waste Company буюу “Хог, хаягдалгүй компани” болох хэтийн зорилготой. Мэдээж энэ бол өнөөдөр, маргааш эсвэл жилийн дараа биелэгдэх боломжтой зүйл биш. Энэхүү хэтийн зорилгодоо хүрэхэд хэдэн жил шаардагдахыг тааж хэлэхэд хэцүү. Гэхдээ бид эерэг өөрчлөлтийн төлөөх алхмаа эхлүүлсэн нь хамгийн чухал. Бидний эрхэм зорилго бол “Байгаль орчинд сөрөг ул мөр огт үлдээхгүйгээр үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх”-д оршино. Үүний дүнд бид үйлдвэрлэлийн гинжин хэлхээний зардлаа бууруулж, зах зээлийн өндөр стандарт тогтоож, шингэн хүнс үйлдвэрлэлийн тэргүүлэгч компани гэсэн нэр хүндээ бэхжүүлэн, байгаль орчны тогтвортой хөгжлөөрөө шинэ хэрэглэгчдийн хүлээлтэд нийцэж ажиллах юм.

Өнгөрсөн жилд бид бизнесийн нэгж бүрийнхээ ус болон эрчим хүчний зарцуулалтын хэмжилт дээр ажилласан билээ. Ингэснээр бид сар бүрийн зарцуулалтаа хэмжин, жил ирэх бүр зарцуулалтаа багасган ажиллах боломжтой болсонд бид туйлын баяртай байна.

APU Company ус, эрчим хүчний хэмнэлтээс гадна хог, хаягдлаа дахин боловсруулах, дахин ашиглах, багасгах зорилт тавин ажиллаж байна. Жишээлбэл өөрсдийн шил, лонхыг боломжит дээд хэмжээгээр дахин ашиглахын зэрэгцээ пивоны шаараар малын тэжээл үйлдвэрлэж болдог. Бидэнд арвин их санаа, санаачилга бий бөгөөд түүнийгээ ч аль хэдийн бодитоор хэрэгжүүлж эхлээд байна. Ялангуяа манай хамт олны хог, хаягдлыг бууруулах санал, санаачилгууд эх оронд нь ямар эерэг нөлөөлөлтэй вэ гэдгийг ойлгож байгаа нь туйлын сайшаалтай юм.

Та Монгол улстай хэр танилцаж байна вэ?

Дашрамд хэлэхэд би гэрэл зураг авах хоббитой. Монгол орон үзэсгэлэнтэй байгаль, өвөрмөц соёл хосолсон газар. Тиймээс энэ жил Монголын үзэсгэлэнт газруудаар аялж, зураг авахаар зорьж байгаа.

Магадгүй танд уриалах юм уу эсвэл хэлэх захиас байвал...?

Энэ сайхан орныг байгаа чигээр нь авч үлдэх, хойч үедээ баялаг болгон өвлүүлэхийн төлөө дор бүрнээ хичээцгээе!

Бидэнд цаг зав гаргасан Танд маш их баярлалаа.


Баярлалаа та бүхэнд.



# ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО

## ХҮНИЙ НӨӨЦ, ХӨГЖИЛ

Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийн эхлэл суурь болж, нэгэн зууны турш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж буй АПУ компани нь салбартаа манлайлж, хүний хөгжлийг дээдлэн, эх орныхоо хөгжил цэцэглэлтэд өөрсдийн хувь нэмрээ оруулж яваа ууган үйлдвэрлэгч АПУ Групп компани нийт 2116 ажилтантай. Дэлхийд шар айрагны үйлдвэрлэлээрээ хоёрт эрэмблэгдэж, 154 жилийн түүхтэй алдарт Хэйнекен компанийн Монгол дахь эзэмшлийн компаниудыг нэгтгэж Монгол Улсын шингэн хүнсний салбарыг чиглүүлэгч компанийн суурийг тавьж, хүчирхэг нэгдлийг бий болгоод байна. 2018 онд компанийн нэгдэн нийлэлтийн хүрээнд “Нэг гэр бүл, нэг зорилго” концепцийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж ажилтан бүр нэг гэр бүл шиг, нэг зорилгын төлөө нэгдмэл байх, нэг үзэл санаа зорилгын төлөө нэгдэх, бие биенээ илүү ойлгох, таньж мэдэх, олон улсад нэвтрэн хэрэгжиж буй дэвшилтэд техник технологи, үйл ажиллагааны онцлог, арга барилууд, төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн.



2018 оны хүний нөөцийн бодлогын хэрэгжүүлэлтийн хүрээнд: “Нэг гэр бүл, нэг зорилго”-ын хүрээнд бүх ажилтнуудад зохион байгуулалттай, тэгш, шударга зарчимд үндэслэсэн, эрх мэдэл олгосон, ээлтэй ажлын байрыг бий болгохын тулд дараах бодлогуудыг амжилттай хэрэгжүүлсэн.

- Ажлын цаг бүртгэлийн тухай журам
- Нэг зэргийн системийг нэвтрүүлж хэрэгжүүлсэн
- Бизнесийн ёс зүйн дүрэм
- Цалин хөлсний тухай журам
- Сонгон шалгаруулах тухай журам
- Гүйцэтгэлийн удирдлагын журам
- Гүйцэтгэлийн урамшууллын журам



## СУРГАЛТ ХӨГЖИЛ:

АПУ компани нь 2018 онд ажилтнуудынхаа хувь хүний хөгжилд чиглэсэн “Нэг гэр бүл, нэг зорилго” концепцийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажилласан ба хүний нөөцийн хөгжлийн хүрээнд ажлын байранд болон хувь хүний мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 12 гадаад улс руу сургалт, дотоод болон гадны байгууллагаас авсан 756 сургалт авсан ба нийт 35185 цагийн сургалтанд 10409 ажилтанг хамруулж амжилттай зохион байгуулсан. (давхардсан тоогоор)

Үүнд:

- Бүх чиг үүргийн захирлууд болон албаны дарга, ахлах менежер, менежерүүдийг хүний нөөцийн газраас зохион байгуулж өөрсдийн боловсруулсан Гүйцэтгэлийн удирдлага, Зан төлөвт суурилсан сонгон шалгаруулалтын аргачлал, Бизнесийн ёс зүйн дүрэм сургалтуудад 354 менежерүүдийг хамруулснаар менежерүүд өөрсдөө процессоо бүрэн эзэмшин авч явах чадавхитай болох боломжтой болсон.
- Анхан шатны менежерүүдийг хөгжүүлэх хөтөлбөр 2 дахь ангийг төгсгөж 42 анхан шатны менежерийг хамруулсан.
- “Нэг баг” зорилго дор 70 гаруй захирал, дарга, ахлах менежерүүдийг хамруулсан семинарыг зохион байгуулсан.

Байгууллагын соёлын судалгаанд бүх ажилтнуудыг хамруулан цаашид хэрхэн сайжруулах төлөвлөгөөт ажлуудыг газар, алба бүр дээр авч хэрэгжүүлснээр энэ нь хүний хөгжлийн KPI нэг хэсэг болох юм.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭМЖҮҮР

- Хүний нөөцийн нэгдсэн тайлан тоон үзүүлэлт болон баримт бичгийн загварыг шинээр үүсгэн FTE хэмжиж эхэлсэн.

## АЖИЛТНУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ

2018 онд “Нэг гэр бүл, нэг зорилго” концепцийн хүрээнд ажилтнууд руу чиглэсэн олон арга хэмжээг зохион байгуулсан ба Үүнд: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Өөдрөг өглөө, Үндэсний их баяр наадам, АПУ Олимп спортын арга хэмжээ, Хүнсчдийн баяр, Төгөлдөр төсөл сонирхлын клубуудын арга хэмжээ, Хамаг монгол урлагийн наадам зэргийг амжилттай зохион байгуулсан.

- Тэтгэвэр, тэтгэмж 230,767,000 төгрөг
- Урлаг, Спорт, олон нийтийн арга хэжээ, шагнал урамшуулал 137 000 000 төгрөг
- Дэмжлэг тусалцаа 241,000,000 төгрөг
- Өдрийн хоол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд -2,391,590,000 төгрөгийн тусламж тус тус үзүүлсэн.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

APU компани нь өөрийн үйлдвэрлэл болон бүхий л үйл ажиллагаандаа Монгол Улсын байгаль орчны чиглэлийн бүхий л холбогдох хууль, тогтоомж, олон улсын стандарт, шаардлагуудыг мөрдөн олон улсын хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ, хүлээлтийг бүрэн хангахад гол анхаарлаа хандуулан ажилласаар ирсэн.

Бидний 2018 оны стратеги зорилтуудын нэг болох “Brewing Better Word” буюу “Сайхан дэлхийг цогцлоох” стратегийн хүрээнд байгаль орчинд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүлээ.

1. Эрүүл ахуй, аюулгүй байдлын уриалах
2. Усны ундаргаа хайрлан хамгаалах
3. Нүүрсхүчлийн хийн ялгарлыг багасгах
4. Эрчим хүчийг хэмнэх
5. Хог хаягдал орчны бохирдлыг багасгах

### ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨСӨЛ

АПУ компаний хэмжээнд үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлыг зохистой хэмжээнд хүртэл бууруулах, дахивар хог хаягдлын эргүүлэн ашиглах хэмжээг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэх, Үндэсний хог хаягдлын менежментийн стратегийн хүрээнд тавьсан зорилтыг хэрэгжүүлэх зорилготой хэд хэдэн чиглэлийн дэд төслийн ажлууд эхлүүлэн ажиллаж байна.

Эдгээр дэд төслүүдийн нэг болох “Эргэлтийн болон эргэлтийн бус төрлийн лонхны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх” дэд төсөл нь гадагшаа чиглэсэн гадаад валютын мөнгөн урсгалыг хааж, дотоодоос татан авах боломжтой эргэлтийн болон эргэлтийн бус лонхны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, татан авах ажлыг эрчимтэй зохион байгуулах мөн энэхүү хөтөлбөрт оролцогч сонирхогч талуудад шаталсан урамшууллын систем нэвтрүүлэх замаар байгаль орчинд, ялангуяа хөдөө орон нутагт хаягдаж буй

хог хаягдлыг багасган бууруулах зэрэг томоохон ач холбогдол бүхий стратегийн төслүүдийн нэг юм.

Мөн бид ажилтнуудынхаа дунд аль болох бага хог хаягдал үүсгэх, боломжтой бол дахин ашиглах зарчмыг баримтлан, хог хаягдлыг зүй зохистой зохицуулах зан үйлийг хэвшүүлэхийн тулд хог хаягдал гарах эх үүсвэр, цэг бүрт тохирох төрлийн хогийн савнуудыг байрлуулсан.

Бид хог хаягдлаа дахивар болон идэвхгүй хаягдал зэргээр дөрвөн төрөлд ангилж, улмаар цааш нь зохих байдлаар хянан удирддаг. Манай үйлдвэрлэлээс гарч буй органик хаягдлууд болох улаан буудай, арвайн соёолжийн хаягдал шаар хөрөнгийн чийглэгийг нь бууруулан мал, амьтны тэжээлийн зориулалтаар малчид, фермерүүдэд нийлүүлж байна.

## УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР

APU компани нь нийт хэрэглэсэн цэвэр усныхаа 60 хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 40 хувийг тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашигласан ба “Ус хэмнэх, саарал усаа дахин ашиглах” хөтөлбөрийг хэрэгжүүлж, цэвэр усны зарцуулалтыг бууруулах, усаа хэмнэх, саарал усыг дахин ашиглах зорилгоор 12 төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр жил бүр 15 000 тонн усыг дахин ашиглаж, дараах нэгж хэсгүүдэд ашиглаж байна.

- Хан-Уул дүүргийн ногоон байгууламж услах цистернуудийг цэнэглэх
- АПУ компанийн 800 гаруй ажилчдын ажлын хувцас хэрэгслийг угаах
- Түгээлтийн автомашинуудыг угаалга цэвэрлэгээ
- Ариун цэврийн өрөө (бочкинд ашиглах)
- Үйлдвэрийн анхан шатны цэвэрлэгээ (шал угаах)

Мөн АПУ компани бохир ус цэвэрлэх байгууламж байгуулахаар төлөвлөж ажиллаж байна.

## ТУНГАЛАГ ТУУЛ АЯН



APU компани нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд тогтвортой хөгжлийн нэг чухал баримтлал болох байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах, хог хаягдлыг бууруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулах чиглэн, ажилчдынхаа санаачилгыг дэмжиж, “Тунгалаг Туул” аяныг жил бүр зохион байгуулдаг билээ. 2018 онд тус арга хэмжээг “Байгаль дэлхийгээ хайрлая” уриан дор 2 компанийн нэгдлийн үйл ажиллагаатай холбогдуулан, аяны цар хүрээг өргөжүүлэн, Улаанбаатар хотын усны ундарга болсон Туул голын эрэг болон Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хараа голын эрэг, бургасан шугуйн 2.5км газрын хог хаягдлыг 500 гаруй ажилчдынхаа оролцоотойгоор цэвэрлэсэн.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ХӨТӨЛБӨР

Эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилгоор цахилгаан хуваарилах түгээх байгууламжийн шинэчлэл, эрчим хүчний хэмнэлттэй системийн суурилуулалт, дулааны алдагдлыг бууруулах хөтөлбөр, уурын конденсацйг халаалтанд дахин ашиглах шийдэл, гэрэлтүүлгийн шинэчлэлт, байгалийн гэрэлтүүлэг ашиглалт, тоног төхөөрөмжүүдийн эрчим хүчний хэмнэлт, эрчим хүчний мониторинг зэрэг хөтөлбөрүүдийг өнгөрсөн 5 жилийн хугацаанд хийж, жилд 180,000квт/цаг эрчим хүчийг хэмнэж байна.

2018онд дэд станц №2-ийн 1000кВа-н трансформатор 0,4кВ-н ячејк тоноглол шинэчлэх тоног төхөөрөмжийг угсрахаар төлөвлөж, зураг төсөл, ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалт хийгдсэн. Энэ тоног төхөөрөмжийг суурилуулснаар цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах, цахилгаан эрчим хүчний алдагдал багасгана.

## ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

APU компани нь Нэгдсэн удирдлагын тогтолцооны бодлого, стратегийн хүрээнд бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаас байгаль орчны талаар илүү хариуцлагатай бодлого баримтлахыг уриалан, тэднийг дэмжин ажилладаг. АПУ компанийн гадаад бэлтгэн нийлүүлэгчдийн 25 хувь нь Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт ISO14001 стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн ханган нийлүүлэгчид байдаг.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД



**АМЬДРАЛ БЭЛЭГЛЭХ SAVE LIFE ТӨСӨЛ**

АПУ ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд JCI Монгол байгууллагын санаачилсан Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/-тэй хамтран хэрэгжүүлдэг "SAVE LIFE" төслийн гуравдугаар шатанд Нярайн мэс заслын дараах тасгийн байрыг өргөтгөж, их засварын ажил хийж, олон улсын стандартын шаардлагад нийцэхүйц тохижилт хийж гүйцэтгэхэд дэмжиж ажиллаа. Бидний хамтран хэрэгжүүлдэг уг төсөл 2018 онд амжилттай хэрэгжиж бодит үр дүнд хүрч байгааг дуулгахад таатай байна.



**ЭФ СИ УЛААНБААТАР БАГ МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ**

АПУ ХК нь "Эф Си Улаанбаатар хөл бөмбөгийн шигшээ баг"-ийг дэмжиж, хамтран ажиллаж ирсэн билээ. 2018 онд "Эф Си Улаанбаатар баг" үндэсний дээд лигийн тоглолтуудаа амжилттай өндөрлөж, өрсөлдөгч "Улаанбаатар сити" багийг (5:0)-ийн харьцаатайгаар ялж "Мазала" үндэсний дээд лигийн мөнгөн медаль хүртсэн юм. Энэ нь бидний хувьд хамтын ажиллагааны нэг үр дүн бөгөөд дэлхийн топ спорт гэгддэг хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд оруулж буй хөрөнгө оруулалт, хувь нэмэр билээ. Нийт баг тамирчдаа амжилтаа улам бататгаж, цаашид лигийн аварга болохыг хүсье!



**"ДАКАР РАЛЛИ 2019" УРАЛДААНД МОНГОЛЫН БАГ ТАМИРЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО**

АПУ ХК нь спортын олон төрөлд хөрөнгө оруулалт хийх замаар баг тамирчдаа амжилт гаргахад нь дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ. Үүний нэг жишээ нь Монгол улсаас "Дакар ралли 2019" уралдаанд амжилттай оролцсон ОУХМ Ө.Бямбадэлгэр, Ө.Бямбацогт, Н.Лхамаа болон багийн хамт олныг дэмжсэн явдал юм. Манай тамирчдын хувьд мотоцикл, SxS автомашины төрөлд тус тус шандас сорьж, Монголын авто спортын түүхэнд үлдэх амжилтыг гаргаад байгаа билээ.



**LET'S DO IT- ЭХ ДЭЛХИЙГЭЭ  
ЦЭВЭРЛЭХ ӨДӨР**

Дэлхийн 150 оронд зохиогддог “Let’s Do it” буюу “Эх дэлхийгээ цэвэрлэх өдөр - 2018” үйл ажиллагааг JCI Монгол байгууллагаас улс орон даяар өрнүүлсэн бөгөөд АПУ ХК дэмжин оролцож, Туул голын эрэг орчмыг хамт олноороо цэвэрлэж нэгдсэн билээ. Та бүхнийг мөн адил ХОГГҮЙ ногоон ирээдүйн төлөө хамтдаа нэгдэхийг уриалж байна!



**APU-ЧУУД ТУСЛАМЖИЙН  
ГАРАА СУНГАЛАА**

АПУ ХК-ийн хамт олноос Баян-Өлгий аймгийн Өлгий сумын үерийн гамшигт өртөж хохирсон иргэдэд зориулан тусламж үзүүлэх зорилгоор 25 сая төгрөгийн хандив цуглуулж хандивын дансанд шилжүүлсэн билээ. Энэ өдөр Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Гылымхан, Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн дарга Н.Тилеухан нар АПУ ХК-д зочилж, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт аймгийн нийт иргэдийн нэрийн өмнөөс талархал илэрхийлж, талархлын бичгийг гардууллаа.



**ТУНГАЛАГ ТУУЛ**

АПУ ХК-ийн ажилчдын санаачилгаар байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр болсон Туул голоо цэвэрлэх, эко орчны бохирдлыг бууруулах зорилготой “Тунгалаг Туул” аяныг нийгмийн хариуцлагаа ухамсарлан 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэ жилийн хувьд АPU Group компанийн хэмжээнд Хан-Уул дүүрэг, Баянзүрх дүүрэг болон Зүүнхараа дахь үйлдвэрүүдийн нийт 1000 гаруй ажилчдыг хамруулан хур хог ихтэй газруудыг цэвэрлэж, олон нийтийг уриаллаа.

## ШАГНАЛ

---

### INTERNATIONAL SPIRITS CHALLENGE 2018.

- Vodka Wheat Standard Gold VIVA Mongolia
- Vodka Wheat Standard Silver SARKHAD Alfa
  
- Vodka Wheat Super Premium Silver Velvet
- Vodka Wheat Super Premium Silver EVOK
- Vodka Wheat Super Premium Silver Chinggis Khan

### MONDE SELECTION

- Silver award Sengur Beer

### THE ASIA MARKETING EXCELLENCE AWARD

- APU DAIRY National winner marketing 3.0 Award, 2018

### ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЯАМ

- Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн 2018



# ТАЙЛАГНАЛ

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2017 он	Нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018 он
<b>ХӨРӨНГӨ</b>			
Үндсэн хөрөнгө	сая.төг	262,403.8	247,931.7
Биет бус хөрөнгө болон гүүдвил	сая.төг	99,597.4	95,782.4
Биологийн хөрөнгө	сая.төг	50.5	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	сая.төг		-
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	6,287.5	902.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	сая.төг	<b>368,339.2</b>	<b>344,616.3</b>
Бараа материал	сая.төг	70,301.8	78,130.1
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	сая.төг	6,961.7	10,917.0
Татвар, НДШ-ийн авлага	сая.төг	94.7	2,435.4
Дансны авлага, бусад авлага	сая.төг	44,029.1	33,225.0
Бусад санхүүгийн хөрөнгө	сая.төг		-
Бусад эргэлтийн хөрөнгө	сая.төг		-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	51,009.0	61,123.0
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	сая.төг	<b>172,396.2</b>	<b>185,830.4</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	сая.төг	<b>540,735.4</b>	<b>530,446.7</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	сая.төг	106.3	106.3
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,094.9	225,299.1
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,795.8)	-
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	78,756.4	84,501.0
Хуримтлагдсан ашиг	сая.төг	87,048.1	132,917.7
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	1,229.5	1,354.1
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	сая.төг	<b>392,439.4</b>	<b>444,178.1</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Урт хугацаат зээл	сая.төг	29,763.7	-
Хойшлогдсон татварын өр	сая.төг	20,353.8	18,549.9
Бусад өглөг	сая.төг	217.3	148.0
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	сая.төг	<b>50,334.9</b>	<b>18,697.9</b>
Богино хугацаат зээл	сая.төг	39,338.0	-
Татварын өр	сая.төг	3,519.3	17,653.1
Бусад өглөг	сая.төг	55,103.7	49,917.6
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	сая.төг сая.төг	<b>97,961.1 148,296.0</b>	<b>67,570.7 86,268.6</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>	сая.төг	<b>540,735.4</b>	<b>530,446.7</b>

<sup>2</sup>Дээр харуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь АПУ ХК-н нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитлагдсан үр дүн ба Монголын Хөрөнгийн Биржийн сайтанд 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр байршуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь аудитлагдаагүй үр дүн болно.



## ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2017 он	Нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018 он
Борлуулалтын орлого	сая.төг	234,038.8	512,928.5
Борлуулалтын өртөг	сая.төг	(164,004.5)	(287,403.8)
<b>НИЙТ АШИГ ( АЛДАГДАЛ )</b>		<b>70,034.3</b>	<b>225,524.7</b>
Удирдлага, борлуулалт, маркетингийн зардал	сая.төг	(33,193.0)	(142,894.8)
Бусад орлого	сая.төг	521.0	1,879.4
Бусад зардал	сая.төг	(1,408.9)	(4,023.1)
Санхүүгийн орлого	сая.төг	18,995.3	199.9
Санхүүгийн зардал	сая.төг	(21,631.3)	(3,602.8)
<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ ( АЛДАГДАЛ )</b>		<b>33,317.3</b>	<b>77,083.3</b>
Орлогын татварын зардал	сая.төг	(9,379.5)	(19,231.6)
<b>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ ( АЛДАГДАЛ )</b>		<b>23,937.8</b>	<b>57,851.7</b>
Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	сая.төг	-	129.6
Валютын ханшийн зөрүү	сая.төг	10.1	-
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО</b>		<b>23,947.9</b>	<b>57,981.3</b>

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	ӨМЧ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	ХУРИМТЛАГДСАН АШИГ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	ХЯНАЛТЫН ЭРХҮЙ ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ДҮН
<b>2018 эхний үлдэгдэл /нэгтгэсэн/</b>	<b>106.42</b>	<b>(0.12)</b>	<b>88,485.13</b>	<b>78,756.44</b>	<b>338,094.87</b>	<b>1,482.92</b>	<b>506,925.66</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	(112,795.80)	(253.47)	(113,049.27)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	(1,382.20)	-	-	-	(1,382.20)
<b>2018 залруулсан</b>	<b>106.42</b>	<b>(0.12)</b>	<b>87,102.93</b>	<b>78,756.44</b>	<b>225,299.07</b>	<b>1,229.45</b>	<b>392,494.19</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	252.44	(375.26)	-	-	(122.82)
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	6,119.76	-	-	6,119.76
Зарласан ногдол ашиг	-	-	(12,164.72)	-	-	-	(12,164.72)
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	57,727.06	-	-	124.60	57,851.66
<b>2018 эцсийн үлдэгдэл /нэгтгэсэн/</b>	<b>106.42</b>	<b>(0.12)</b>	<b>132,917.70</b>	<b>84,500.95</b>	<b>225,299.07</b>	<b>1,354.05</b>	<b>444,178.07</b>

<sup>3</sup>Дээр харуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь АПУ ХК-н нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитлагдсан үр дүн ба Монголын Хөрөнгийн Биржийн сайтанд 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр байршуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь аудитлагдаагүй үр дүн болно.

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2017 он	Нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018 он
<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>			
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	48,533.3	88,165.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	24,451.3	(13,520.3)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(38,625.1)	(63,971.2)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	34,359.4	10,674.2
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	сая.төг	16,790.1	51,009.0
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	сая.төг	51,009.0	61,123.0

<sup>4</sup>Дээр харуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь АПУ ХК-н нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитлагдсан үр дүн ба Монголын Хөрөнгийн Биржийн сайтанд 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр байршуулсан тайлангийн 2017 оны үр дүн нь аудитлагдаагүй үр дүн болно.

## ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

### ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн.

Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт ("СТОУС") 10 буюу "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн хэдий ч Групп компани нь нэгдсэн бүртгэлийн бодлого баримтлаагүй болно. Тиймээс хөрөнгө оруулалт, охин компаний цэвэр хөрөнгө бодит үнэ цэнээр хэмжигдээгүй.

### ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

Хөрөнгө оруулалт болон охин компаний эздийн өмчийг тохируулахдаа дансны үнийг ашигласан болно.

Хөрөнгө оруулалт болон охин компаний цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох хөрөнгийн дахин үнэлгээний ажил явагдаж байна.

Бүртгэлийн болон толилуулгын валют

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн

засгийн орчны үндсэн валют болно.

### ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

### ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

### ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

### БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

### БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрнө.

### ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### ТҮРЭЭСИЙН ХӨРӨНГӨ

Түрээсийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, эзэмшил компанид бүрэн шилжсэн гэж үзсэн тохиолдолд санхүүгийн түрээсээр ангилж, бүртгэдэг. Санхүүгийн түрээсийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэдэг.

### БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

### ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

#### ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

#### ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

#### САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

### АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

### НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг

## ХУВЬЦААТ КАПИТАЛ ЭНГИЙН ХУВЬЦАА.

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

### ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

## ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

### Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар

Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон. Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн.

### Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Н эмж г аргасан хувьцааны бодит үнэ цэнэ б олон х уулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

## ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

### БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

### БУСАД ОРЛОГО.

Компаний үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

### ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн хугацаанд нийт түрээсийн зардлын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг.

### САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

### ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

### НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

### ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.



## ТАЙЛБАР ТОЛЬ

# ТАЙЛБАР ТОЛЬ

## ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

## ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

## ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчиддээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

## ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

## ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

## ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

## УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

## ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

## БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

## МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

## МӨНГӨН СУУРТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

## АККРУЭЛ СУУРТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

## ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

## ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

## Өр төлбөр

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

## УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

## БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

## НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

## ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар ( улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан



**БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

**ББӨ**

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

**НА**

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

**ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

**ХТӨА**

Хүү татварын өмнөх ашиг

**ЦА**

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

**ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ**

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

**ОАТ**

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

**МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

**ҮҮАМГ**

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

**ГХО**

Гадаадын хөрөнгө оруулалт

# APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Монгол улс, Улаанбаатар хот 17040,  
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 48.  
Утас: 11-344837  
[www.apu.mn](http://www.apu.mn)